

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-33</i>
<hr/>	
1.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	5-33
2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай	33

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 10 дугаар сарын 02-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Баттулга;
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Л.Мөнхбаатар, С.Одонтуяа,
Дав.Цогтбаатар.

Нэг.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Мөрдөн байцаах албаны дарга П.Очбадрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Баасанжаргал, Г.Уянгахишиг, Х.Тэмүүжин нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Мөрдөн байцаах албаны дарга П.Очбадрах нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Д.Ганбат, Х.Баасанжаргал, О.Номинчимэг, М.Нарантуяа-Нара, Б.Бат-Эрдэнэ, Д.Цогтбаатар, Г.Уянгахишиг нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг хүнийг саатуулсан үеэс эхлэн тооцох бөгөөд энэ хуулийн 22.2-т заасныг танилцуулна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг хүнийг саатуулсан үеэс эхлэн тооцох бөгөөд энэ хуулийн 22.2-т заасныг танилцуулна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-т заасны дагуу “Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно.” гэж заасны дагуу горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9

Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-т заасны дагуу “Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно.” гэж заасны дагуу гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17

58.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 68.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 10 минут үргэлжилж, 22 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 77.3 хувийн ирцтэйгээр 12 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин
Д.Сүхбаатар” танхим 10 цаг 27 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Ингээд 2024 оны намрын чуулган эхлээд Хууль зүйн байнгын хорооны анхны хурал бас эхэлж байна. Тэгээд энэ бид нарын хувьд нэлээн олон ажил урд төлөвлөгдөж хийгдэхээр байгаа. Их Хурлын даргын зүгээс ч гэсэн нэлээн олон ажил явуулъя гээд та бүгд өөрсдөө мэдэж байгаа. Тавиад ажлын хэсэг гаргачихсан. Нэлээн том том юмнуудыг эрчимтэй хууль эрх зүйн орчныг өөрчилж гэсэн бодлого гаргаад явж байгаа.

Тэгэхлээр манай Хууль зүйн байнгын хороон дээр ч гэсэн бас нэлээн ачаалал ирж ажиллах болно. Яагаад гэвэл хүний эрхийн асуудал, Хууль тогтоомжийн тухай хуулийн асуудал гээд нэлээн олон асуудлууд орж ирнэ ээ. Хэдүүлээ тэгэхээр бас нэлээн сонсгол байгаа. 11 сарын 20-нд гээд төлөвлөчихсөн нөгөө хүний эрхийн асуудлаар гэх мэт. Ингээд эрт нэлээн эрчимтэй ачаалалтай ажиллах шаардлага гарна бидний хувьд. Өнөөдрийн хуралдааныг тэгээд эхлүүлж байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ингээд хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар хуралдаанд ирсэн байгаа гишүүдийг Норовын Алтанхуяг, Баасанжаргал гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Ганбат гишүүн, Нарантуяа гишүүн, Номинчимэг гишүүн, Отгонбаяр гишүүн, Сайнзориг гишүүн, Сандаг-Очир гишүүн, Тэмүүжин гишүүн, Уянгахушиг гишүүн, С.Эрдэнэболд гишүүн гэсэн ийм ирцтэйгээр өнөөдрийн ирц бүрдсэн байна аа. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 2 асуудал байгаа. Хэлэлцэхээр төлөвлөсөн.

Нэгдүгээр асуудал, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 3 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан/ ийм хуулийн төсөл орж ирж байгаа. Энэ анхны хэлэлцүүлэг байгаа.

Хоёрдугаар асуудал нь сонгон шалгаруулалтын бүртгэлийн хугацааг тогтоож хүсэлт материал хүлээн авах тухай энэ Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрээ өгнө үү? Уянгахушиг гишүүн яагаад нэр нь гараад явчав. Больчихсон уу? Тэгвэл Сайнзориг гишүүнээр ингээд тасаллаа.

Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа.

Нэгдүгээрт Цогтбаатар даргад бас нэг хүсэлт байгаа. Даргын зөвлөл дээр орох газрын хуулиуд, төрийн

өмчийн болоод ТӨК-ийн тухай хууль орж ирвэл Хууль зүйн байнгын хороо бас хамтарч хэлэлцэх ёстой гэдэг энэ зарчмыг илэрхийлж өгөөч ээ. Манай Байнгын хорооны гишүүд татгалзахгүй байх. Энэ дандаа хууль зүйн үр дагавартай асуудлууд хэлэлцдэг. Яг Эдийн засгийн байнгын хороон дээр нөгөө хууль зүйн компанийн засаглал талаасаа ч юм уу тэр газрын эдийн засгийн эргэлтэд оруулж буй эрхийн төрөл талаасаа Иргэний хууль, Үндсэн хуулийнхаа юмнуудтай. Ерөөсөө энэ өнгөрсөн хугацаанд батлагдсан хуулиуд нийцэхгүй байгаа шүү дээ. Манай газрын хуулийн эдийн засгийн эргэлтэд орохгүй байгаа юм чинь Иргэний хуультайгаа нийцээгүй. Бид нар өөрсдөө монголчлоод эрхийн төрөл зохиочихсондоо л бүх юм нийлдэж байгаа юм. Тэгэхээр энэ асуудлуудыг цэгцлэх үүднээс би бас энэ хуулиуд орж ирвэл бас даргыг Байнгын хороо даргын зөвлөл дээр илэрхийлж Эдийн засгийн байнгын хороотой магадгүй холбогдох Байнгын хороотой хамтарсан байдлаар хэлэлцэх энэ байр суурийг илэрхийлж өгөөч ээ.

Дампуурлын хууль байна. Энэ бол цэвэр Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжилсэн процесс. Гэтэл аваачаад Эдийн засгийн байнгын хороон дээр эдийн засгийн асуудал гээд өгчихдөг. Хэн ч тэнд ойлгодоггүй. Өнгөрсөн 8 жилийн парламент тэрнээс ч өмнөх дээр. Тэгэхээр ийм асуудлуудыг бас Цогтбаатар дарга ХЗБХ-оор заавал хамтарч хэлэлцэх ёстой гэдэг байр суурийг хэлж өгөөрэй гэдэг зүйл нэгдүгээрт байгаа юм.

Хоёрдугаарт нь нэг асуулт байна аа. Яах вэ Цэцийн ший дүгнэлтийг бид нар хүлээж аваад шийдвэрлэсэн. Уг нь Үндсэн хууль зөрчөөгүй агуулга байсан. Бид нийцүүлж зүгээр агуулгыг тодруулах шаардлага байсан уу гэвэл байсан.

Тэгэхээр миний асуух гээд байгаа нь түр саатуулах шийдвэр түүний үндэслэлийг шалтгааныг тухайн этгээдэд танилцуулж гэж байгаа юм. Утсаар танилцуулчихвал яах вэ? Зайнаас танилцуулчихвал яах вэ?

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн ээ наадах чинь та яг хэлэлцэх асуудлаа ярь. Тэрийгээ хэлэлцэх үедээ энэ дээр нэмж асуудал оруулах уу үгүй юу гээд. Харин таны тэр эхний ярьж байгаа хүсэлт дээр ингэе тэгэх үү? Би Байнгын хорооныхоо гишүүдэд бүгдээрэнд нь ажлын журмаар хэдүүлээ дотоод нөгөө сүлжээгээрээ ийм ийм хуулиуд гээд та яг саналаа гаргаад хэлээдэх. Тэгээд хэдүүлээ дотроо ганцхан таны саналаар явахгүй бас гишүүд маань өөр юм нэмж магадгүй. Тэгэхлээр тэр юунуудаа аваад тэгээд хэдүүлээ дундаасаа яг ийм ийм хуулиуд дээр Хууль зүйн байнгын хороо оролцъё гэдэг тэр саналыг би нээлттэй тавьж болно. Зүгээр тэрийгээ харин хэдүүлээ дотроо нэг яриадахъя тэгэх үү?

Тэгвэл ингээд өөр санал байхгүй бол энэ хэлэлцэх асуудлаа тохирлоо. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Нэрс нь хаана байна? Б.Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, П.Очбадрах ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны дарга гэсэн ийм 2 хүн ажлын хэсгийг төлөөлж орж ирж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж

заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье ээ. Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн I дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор энэ асуудлыг бид бас Үндсэн хууль зөрчсөн байна гээд хүлээгээд авчихсан. Тэгэхдээ энэ дээр нэг зүйлийг би эхлээд тодруулъя гэж бодож байна. Яг санал болгож байгаа томъёолол дээр түр саатуулах хугацааг түр саатуулах шийдвэр, түүний үндэслэл шалтгааныг тухайн этгээдэд танилцуулж холбогдох эрх үүргийг нь тайлбарлаж өгсөн үеэс эхлэн эхлэн тоолно гээд тавьчихаж байна. Зарим үе дээрээ энэ дээр бас магадлалууд бий. Зарим эрх бүхий байгууллага байхгүй үеүд дээр, ЭСЯ-дуудтай нь холбогдуулах хил орчимд байна шүү. Гэх зэрэг ийм нөхцөл шаардлагууд гарахад энэ чинь аль үеэсээ эхэлж тоглох болчихож байна гэдэг нэгдүгээрт юм байгаа. Яг тодруулах юмнууд байж байдаг.

Хоёрдугаарт яах вэ танилцуулаагүйгээр шууд түр саатуулах байранд хийчхэж байгаа юм. Энэ үе чинь өөрөө эргээд магадгүй практик дээр бас гарахыг үгүйсгэхгүй. Тэгэхээр энэ нөгөө түр саатуулах байранд шууд аваачаад шийдвэр энэ тэрээ хэлээгүй ч гэдэг юм уу, процессын алдаа гаргалаа хийлээ гэхэд эндээс эхлээд тоолж байгаа энэ агуулга энэ та хэдийн санал болгож байгаа томъёолол дотор агуулгын хувьд багтсан уу? Өөрөөр хэлэх юм бол энэ үйлдэл нь танилцуулсан гэдэг үйлдэл агуулга дотор орох уу үгүй юу гэдэг зүйлийг I дүгээрт I тайлбарлаад өгөөч ээ.

Хоёрдугаарт магадгүй яг шийдвэрийг танилцуулаад эрх үүргийг нь тайлбарлаад өг өгч байтал оргон зайлчихвал танилцуулснаар энэ хугацаа товлогдоод явж байгаа оргон зайлчихсан хүн дээр чинь цаашидаа яаж түр саатуулагдсан эсэхийг нь тогтоох юм бэ. Практик дээр бол энэ хэцүү. Тэгэхээр энэний ньюансууд дээр зүгээр практик дээр хүндрэл гарах уу? Яг энийг томъёоллыг бэлтгэсэн хүмүүс дээр 2 асуултыг хариулж өгөөч ээ.

Нэгдүгээрт яг энэ танилцуулсан гэдэг дотор түр саатуулах байранд шууд аваачаад хийж байгаа энэ агуулга багтаж байгаа юу?

Хоёрдугаарт танилцуулаад эрх үүргийг нь тайлбарлаж байтал булан тойроод гүйчихлээ. Энэ үеэс чинь танилцуулаад хугацаа тоолчихоод явж байхад түр саатуулагдсан гэдэг дээр явах юм уу? Эсвэл энэ яг яах вэ? Энэ дараагийн үргэлжилсэн процесс нь аль хуулиараа зохицуулагдах юм бэ?

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн яг энэ асуудлыг бид нар хэлэлцэж байхад хэлж байсан саналыг би санаж байна. Яг энэ агуулгынхаа хүрээнд ч бас асууж байна. Би тэгээд өөрийн чинь ярьж байгаа энэ зүйлийг зөв гэж бодож байгаа учраас бүр цагдаагийн газар руу өөрөө яриад наад амьдрал дээр чинь Үндсэн хуулийн цэцийн зүгээс ийм дүгнэлт шийдвэрээ гаргачихсан, бид нар эд нарт энэнд нийцүүлж шийдвэрээ гаргана аа. Яагаад гэвэл хүний эрх төвтэй ийм бодлоготой бид нар хуулиуд гаргана аа гээд. Энэ Их Хурлын хувьд бүүр тодорхой заачхаад байна шүү дээ бид нар. Тэгэхээр тэр талдаа бид нарын гаргаж байгаа шийдвэрүүд энэ бодлогоо барина. тэгээд цагдаагийн албаны зүгээс бас энэ дээр бид нар бүүр тусгайлан би өөрөө ярьж байгаад энэ дээр та нар заавал саналаа оруулаарай гээд оруулсан

байгаа. Энд зүгээр нэг зүйлийг миний бодож байгаа, одоо энэ чинь бид нар яг хэлэлцээд л явж байгаа юм чинь жишээлбэл өөрийн чинь ярьж байгаа энэ миранда зарчмыг яг хэрэгжүүлээгүйгээр бариад хийх тухай ойлголт бол ерөөсөө байж болохгүй. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагын зүгээс өөрийнхөө барих зарчим журмыг заавал барьсан байх ёстой.

Бариагүй алдаад хийчихсэн байхад тэгвэл процесс эхэлж болох уу? Тэгвэл саатуулж болохгүй байхгүй юу? Харин тийм яг үнэн. Тэгэхлээр миний юун дээр тэр хэлэлцүүлгээр барих тухай ерөөсөө ойлголт хэдүүлээ одоо энд цагдаагийнханд ч өгч болохгүй шүү дээ. Заавал тэрийгээ гүйцэтгэж байж барина. Энэ харин тайлбарлаж байх үед зугтах юм бол миний зүгээр бодож байгаагаар одоо энд хэдүүлээ л ярьж байгаа юм чинь. Зугтчихаж байгаа бол саатуулах ажиллагаа угаасаа эхлэхгүй болчихож байгаа байхгүй юу. Тэгээд ажлын хэсэг энэ дээр хариул даа. 6 дугаар микрофон өгье.

Б.Батзориг: Ажлын хэсгээр хэлэлцээд саяын нөгөө гишүүдэд тарааж өгсөн байгаа томьёоллоор оруулсан байгаа. Угаасаа Үндсэн хуулийн цэцийн шийдвэр Улсын Их Хурлаас хүлээж авсан шийдвэртэй холбогдуулаад саатуулах шийдвэр түүний үндэс шалтгааныг тухайн этгээдэд танилцуулж, холбогдох эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөн үеэс буюу саатуулсан. Тэр цаг хугацаанаас эхлээд цаг хугацааг нь тооцно гээд. Яг одоо амьдрал дээр бол Монгол Улсын 21 аймаг 9 дүүрэг дээр нийслэлийн нутаг дэвсгэр болон аймгийн төвийн нутаг дэвсгэрүүд дээр бол энэхүү хуулийн хэрэгжилтийг энэхүү цаг хугацааг хангах бүрэн боломжтой байгаа. Амьдрал дээр заримдаа цөөн байдаг тохиолдлууд байдаг. Ууланд явж байгаа жишээлбэл амьдрал дээр гардаг нөгөө

нинжа нар гэж нэрлэгдээд байдаг, нөгөө гар аргаар ашигт малтмал олборлосон иргэд аль нэг аймгийн нутаг дэвсгэр суман дээр цугларчихдаг. Тухайн аймгийн тухайн сумын эрүүхэв журмын нөхцөл байдал хүндэрдэг, гэмт хэргүүд гардаг, зөрчлүүд гардаг. Энэ асуудал дээр цагдаагийн алба хаагч нар очоод шалгах шаардлага үүсэх тохиолдолд тухайн этгээдүүд нь ихэвчлэн дандаа бичиг баримтгүй хүмүүс байдаг, нэгдүгээрт.

Хоёрдугаарт өөрийгөө худлаа хэлдэг. Жишээлбэл иргэн Батзориг гэж өөрийгөө худлаа хэлдэг. Яг ингээд шалгаад үзэхээр нөгөөдөх нь Батзориг биш Батболд гэдэг юм уу ийм байдаг. Үүнийг нь шалгах гэхлээр өндөр хөгжилтэй зарим улсуудад бол маш богино хугацаанд шалгах боломж бололцоо нь байгаад байдаг хэдий боловч яг манай нутаг дэвсгэрийн хэмжээнд интернэт сүлжээ цагдаагийн байгууллагын цахим сүлжээ, мэдээллийн сантай холбоотойгоор тухайн иргэнийг хэний хэн бэ гэдгийг тодруулах тогтоохын тулд заавал цагдаагийн байгууллагын мэдээллийн сан сүлжээтэй холбогдсон орчинд очиж байж хэн бэ гэдгийг нь тогтоох шаардлага үүсдэг. Энэ дээрээ хүндрэл учирдаг аа. Сайнзориг дарга микрофоныг нь өгье.

П.Сайнзориг: Миний яг асуусан асуултад хариулсангүй ээ. Би зүгээр нэг л зарчмыг Байнгын хорооны гишүүддээ бас уриалах гэж байгаа юм. Бид хэд бас хүний эрхийн төлөө бүх зүйлүүд явж байгаа. Гэтэл энэ Цагдаагийн хуулийн 26.2 чинь өөрөө Үндсэн хууль зөрчөөгүй байсан байхгүй юу. Энэ агуулгыг бид хэд Үндсэн хууль зөрчөөд гээд энэ шийдвэрийг авчихаар энэ одоо энэ Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйл дээр байж байгаа. Юу вэ гэхээр Үндсэн хуулийн цэцээр Үндсэн хууль

зөрчсөн гэдэг агуулгыг бид нар сэргээж болдоггүй байхгүй юу. Энэ аливаа юу гэдэг юм. Түр саатуулах байранд хийж байгаа энэ үйлдлээ бид нар цаашидаа хэрэглэж болохгүй. Энэ нь өөрөө эргээд сэргээчихээр энэ агуулга дотор багтаж ойлгоно гэхээр Үндсэн хуулийг бид нар зөрчсөн энэ агуулгыг сэргээж байгаа юм. Урьд нь бид хэд яах вэ нэгэнт өнгөрсөн. Уг нь бол Үндсэн хууль зөрчөөгүй байна. Харин бид энийгээ сайжруулах ёстой юм байна аа. Үндсэн хуулийн тэр түр саатуулах гэдэг тэр агуулга хүрээнд багтаж нийцээгүй байна гэдэг агуулгаар бид хүлээж аваад хуулиа хурдан засъя гэдэг саналыг би хэлж байсан. Энэ чинь өөрөө эргээд хамгийн том зарчим байхгүй юу. Одоо энэ Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйл дээр би хэлье.

Хэрэв эрх бүхий байгууллага албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрийг хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл гэж байгаа юм. Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэцэд маргаан хянан шийдэх ажиллагааг шууд хийж болно. Тэгэхээр бид хэд уг нь түр саатуулах гэдгийгээ өргөжүүлээд морин дээрээ суулгаснаар, машиндаа оруулснаар эсвэл шийдвэрийг хэлснээр гээд ингээд өргөжүүлэх ёстой байтал аваачаад ингэж ерөөсөө л нийтээрээ ингэж массаараа Үндсэн хууль зөрчсөн байна гээд явчхаж байгаа юм. Тэгэхээр бид хэд цаашидаа энэ цэцийн шийдвэрийг хүлээж авахдаа маш сайн ярилцахгүй бол хүний эрхийн төлөө бүгд явж байгааг ойлгож байгаа. Би бас тайлбараа түрүүн тухайн үед л дутуу хэлээд байж. Тэгэхээр энэ агуулга буцаагаад ингээд сэргэх гээд байна гэдэг зүйл дээр нэгдүгээрт хэлмээр байна.

Хоёрдугаарт энэ оруулж ирсэн томъёолол чинь яг нөхцөл байдлыг

тайлбарласнаар түр саатуулах хугацааг тоолж эхэлж байгаа юм. Тайлбарлаад дууслаа хүн оргоод гүйчихлээ. Энэ дээр яах вэ гэдэг зүйлээ жишээ нь оруулж ирээгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ерөөсөө томъёолол болж байгаа юм уу энийгээ ер нь дахиад сайтар ажлын хэсэг ажиллах ёстой юм биш үү? Ингэж өнгөц хийвэл.

Д.Цогтбаатар: Үндсэн хуулийн цэцийн шийдвэр чинь ерөөсөө саатуулах тухай, саатуулах хүний эрх зөрчлөө гэж заагаагүй шүү дээ. Угаасаа энэ ялангуяа эрүүгийн одоо хуультай холбогдолтой нөхцөлүүд чинь хүний эрхэд халдах цонхыг нь нээж өгч байгаа. Яагаад гэвэл халдах нөхцөл амьдралд гардаг гэмт хэрэгтнийг эрхтэнд нь халдаж байж л хууль хэрэгжиж эхэлж нөгөө гэмгүй хүмүүсийн эрх хамгаалагдаж байгаа учраас энд саатуулах тухай асуудал Сайнзориг гишүүн ээ ерөөсөө яригдаагүй шүү дээ. Саатуулах хугацааг хэзээнээс тооцож эрхлэх вэ гэдэг хугацааны тухай л асуудал яригдсан. Тийм.

Тэгээд би зүгээр ингэж бодож байгаа юм. Яг наадхыг чинь бид нар одоо ингээд дутуу хэлэлцсэн гээд энэ бүх гишүүдээ сууж байхад бид нар хэлэлцээд л энэ асуудлаараа шийдвэрээ гаргасан. Энэ процедураараа явсан зүйл. Тэгэхлээр одоо та энд ингээд суугаад би тэр үедээ дутуу тайлбарлаж ч юм уу энд хүмүүс нэг их дутуу тайлбарлагдаад дутуу ойлгоод саналаа гаргаад байсан гишүүн байхгүй шүү дээ. Бүгдээрээ энийгээ аягүй сайн ойлгож байж гарсан. Үндсэн хуулийн энэ юуг зөв гэж би бодож байгаа. Харин таны би хэлээд байгааг аягүй сайн сонсож байгаа учраас би өөрөө хэлж байна шүү дээ. Цагдаа руу хандаад амьдрал дээр наад гарах энэ нөхцөл чинь яах вэ гээд.

Тэгэхээр би байна шүү дээ ингэж байгаа юм. Би энийг тэгээд протоколд хэлж үлдээх гээд байгаа юм. Бид нар энэ юугаа Үндсэн хуулийнхаа цэцийн шийдвэртээ нийцүүлээд гаргана аа. Харин энэ дээр одоо энэ нөхцөл байдалдаа тааруулаад тэр амьдрал дээр зарим мянганаас нэг удаа ч гэсэн гарах тохиолдолд ажилладаг хууль гаргахыг хууль тогтооно гэж байгаа юм. Түүнээс мянганаас 999 нь зүгээр юм чинь мянгад үйлчлэхгүй хууль гаргаж болохгүй. Бид нарт тийм эрх байхгүй. Тийм нүх сүв гарч байгаа бол цагдаагийн байгууллагад энийгээ гүйцээгээд боловсруулаад орж ир ээ. Бидний барих зарчим ямар ч тохиолдолд хүний эрхээ бол хамгаалах талдаа шийдвэрээ гаргана. Ажилд нь саад болох нөхцөл байгаа бол нэмж оруулж ирэх боломжийг бид нар нээж үлдээж байна гээд хэлж байгаа юм. Ийм байна тэгээд ажлын хэсэг бас гүйцээгээд хариулчих. б дугаар микрофон.

П.Очбадрах: Мөрдөн байцаах албаны дарга хурандаа Очбадрах. Хууль зүйн байнгын хорооны дарга Сайнзориг гишүүний сая гаргаж байгаа саналыг хүлээж авч байна. Ер нь бол яг л бодит амьдрал дээр тулгамдаад байгаа энэ түр саатуулахтай холбоотой зохицуулалтыг сая манай Батзориг хурандаа хэлж тайлбарлалаа. Бид бол энэ Үндсэн хуулийнхаа мэдээж гаргаж байгаа энэ дүгнэлттэй холбоотойгоор засаж сайжруулъя. Энэ цагдаагийн албаны тухай хуулийн 26.2-т байгаа томъёоллыг бол цагдаагийн байгууллага дахиж эргэж нягталъя. Бид бол саналаа арай төгөлдөржүүлъя. Энэ амьдрал дээр байгаад байгаа энэ тулгамдаж байгаа асуудлуудаа аль болох хууль зүйн үндэслэлтэй саналаа та бүхэнд бас эргэж танилцуулъя. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Манайд тэгвэл цагдаагийнхан бас сайн ажиллах хэрэгтэй. Наанаас чинь болж нэг талдаа тэнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесст оролцож байгаа ийм залуучууд алба хаагчид чинь буруутгагдана. Нөгөө талдаа яг тухайн гэмт хэргийн сэжигтнийг ч юм уу гэмт хэрэг сэрэгдэж байгаа хүнийг заачхаад зогсож байгаа хохирогчид мэлрээд гайхаад хоцрох байхгүй юу. Тэгээд бид хэд би нэг л зүйлийг хэлж байгаа юм. Саатуулах тухай ерөөсөө яриагүй. Саатуулсныг хэзээнээс эхэлж тооцох вэ гэдэг хугацааны факт болгоныг тодорхой тохиолдол болгоныг бид нар энд дурдаж байна шүү дээ. Энэ танилцуулах гэдэг ерөнхий болоод магадгүй энэ процессыг жоохон зөрчилтэй байдлаараа зөвхөн шууд машиндаа суулгачихсан байхыг юу гэж ойлгох вэ? Энэ бүх зүйлүүд чинь дараа нь хүний эрхийг зөрчөөд эхлэх байхгүй юу. Энэ ажиллагаанууд чинь хууль бус болоод ирнэ. Тэгэхээр бид хэд уг нь энэ зүйлүүдийг өргөжүүлж л хуульчлах ёстой байсан болохоос биш Үндсэн хууль зөрчсөн байна гэж хүлээж аваад ингээд өөрсдөө муйхарлаад Үндсэн хуулийн агуулгыг дахиж шууд бусаар ингээд сэргээх гээд байж байгаа нь боломжгүй болчихоод байгаа юм. Би ерөөсөө хүний эрхийн төлөө л бас явж байгаа. Харин бид хэд сэтгэл хөдлөл багатайгаар жишээ нь юмаа тал талаас нь ярьж байж авахгүй бол ийм үр дагаварт хүрчхээд байгаа байхгүй юу. Би энийг л хэлж байгаа юм.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн ээ энд гишүүддээ одоо 11 гишүүнийг та сэтгэл хөдлөлд автаад нэг хэдэн мангар хүн сууж байгаа юм шиг яриад байж болохгүй шүү дээ. Үгүй ээ үгүй тэгж хэлээд байна шүү дээ та. Тэгж шийдвэр гарсан байхгүй юу. Үндсэн хуулийн цэцийн чинь дүгнэлт тэгж гарсан. Та барих нөхцөлийг нь цагдаагийн машинд оруулаад

суулгачхаад тэрийгээ бариагүй гэж тооцох гээд байна шүү дээ. Тэгж яриад байна шүү дээ.

Цагдаагийн машинд оруулаад суулгачихсан л бол наадах чинь цагдаагийн хяналтад орж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэн дээр чинь ерөөсөө Үндсэн хуулийн цэцийн шийдвэр. Яг аль цагаасаа тооцох вэ гээд цагдаагийн хяналтад бодитоор орчихсон л бол тэр миранда дурдаагүй байсан ч орчхож байгаа байхгүй юу. Тэр цаг хугацааг нь л хэлж өгөөд байгаа байхгүй юу. Харин тэгээд тэр мирандагаа дурдаагүй хийчихсэн байгаа бол тэр саатуулах үйл ажиллагаа нь буруу бөгөөд саатуулчихсан гүйцээ. Харин тэрийг буруу хийсэн цагдаатай хариуцлага тооцох тухай л асуудал яригдаж эхэлж байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл энэ чинь иргэнийхээ эрхийг хамгаалаад тэр бол илүү хариуцлагатай, илүү процедуртай ажиллах тухай л бид нар яриад байна шүү дээ. Тэгээд энэ цагдаад би одоо хэлчихлээ шүү дээ. Энэнээс илүү би яаж хэлэх юм. Энэ дээрээ нэмээд та нар өөрчлөлт оруулах, амьдрал дээрээ тэр гарч байгаа юманд өөрчлөлт оруулах боломжийг нээж өгч байна аа. Сайнзориг гишүүн өөрөө очоод энэ цагдаатай уулзаад тэгвэл яриач. Одоо энэ асуудал орж ирэх нь тодорхой байгаад тэгээд би тэр таны яриад байгаа тэр цагдаатай бид нар яриад энэ саналаа нэгтгээд оруулж ирж байна. Танд өөрт чинь өөр Их Хурлын гишүүн нээлттэй байгаа. Би энийг чинь тусгайлан зааж өгөөд тайлбар хийж өгөөд байна шүү дээ.

Баасанжаргал гишүүнд үг өгье.

Х.Баасанжаргал: Надад нэг асуулт байна ажлын хэсгээс. Бид нар зөрчлийн яг энэ томъёоллоо харахаар одоо энэ Цагдаагийн албаны тухай хууль шүү дээ. Цагдаагийн албаны тухай

хуулийн 26.2-т өөрчлөлт орж байгаа боловч 26.1-ээ хэдүүлээ харна гэсэн үг. 26.1-ээ харахаар цагдаагийн албан хаагч нь гэмт хэрэг зөрчил үйлдсэн сэрдэгдэж байгаа хүнийг саатуул тухай байгаа байхгүй юу. Гэмт хэрэг, зөрчил хоёр дээр. Буцаагаад Зөрчлийн тухай хуулиа харахаар Зөрчлийн тухай хуулийн 5.2 дээр хүнийг саатуулах тухай процесс орж ирж байгаа гэсэн үг. Тэгэхээр ажлын хэсгийнхэн энэ Зөрчлийн тухай хуулиар, Эрүүгийн тухай хуулиар энэ хүнийг саатуулах ажиллагаа чинь өөрөө энэ процессын хуулиудаараа зохицуулагдаад явж байхад дахиад бид нар Цагдаагийн тухай хуулиар яг хэзээнээс хугацаа эхэлж тоолох тухай ингэж цагдаагийн албаны тухай хуульд орох нь ер нь зөв үү гэдэг нэг асуулт байна. Одоо яах вэ тэгээд найруулга дээр саналаа дараа нь хэлчихье.

Д.Цогтбаатар: Яг саяын энийг хэлэлцэж байх явцад энэ асуудал чинь бас гарч ирж байгаа юм. Энэ уг нь процесс байхгүй юу өөрөө. Тэгтэл ингээд цагдаагийн албаны хуулиараа зохицуулаад явчихсан байж байгаа учраас энийгээ тодруулах юмнуудыг би цагдаад хэлээд байгаа чинь бас энэ байхгүй юу. Процессынхоо хэсгийг Цагдаагийн хуульд авчраад ингээд хийчихсэн байгаад байгаа юм. Яах вэ гэхдээ аль ч оронд ийм юу бий. Энэ чинь ингээд нийлээд процесс гэдэг үг чинь зөвхөн процессын хуульд заагдсан процесс биш. Процесс өөр хуулиар зохицуулагдаад явж байгаа бол энэ эрх зүйн орчныг нийлүүлээд процессын хууль гэж нэрлэдэг шүү дээ. Тэгэхээр тэр утгаараа би бол ойлгож байгаа. Энийгээ бас цагдаагийнхан эргээд харна биз. Ер нь бол энэ нийлээд Монголын процессын эрх зүй юу юм бэ гэвэл Цагдаагийн хууль, угаасаа хуулиуд ч эхнээсээ тэгж заадаг шүү дээ. Энэ хууль болон бусад хуульд заагдсан энэ зохицуулалтууд орно гээд яриад л явдаг шүү дээ.

Тэгэхээр Монголын тэр процессын эрх зүй өөрөө бол олон хуулиас л бүрдэж байгаа л даа. Тэгээд цагдаагийн зүгээс хариулах уу? Энэ дээр 6 дугаар микрофон.

П.Очбадрах: Асуултад хариулъя. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дээр ганцхан үндэслэл байдаг. Энэ нь юу вэ гэхээр холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор гэсэн байгаа. Тэгэхээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд ямар нэгэн зөрчил үйлдсэн ямар нэгэн зөрчилд шалгагдах ямар нэгэн зөрчилд баригдсан этгээд байна гэж ойлгож болно. Харин Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд гэмт хэрэг зөрчилд холбогдуулан шалгах хүний нэр хаягийг тодруулах зорилгоор гэж байгаа юм. Тэгэхээр энэ Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйл нь өөрөө яг олон улсын бусад улс орнуудад байдаг Америк Япон зэрэг улс орнуудад байдаг нийтлэг нэр томъёо. Яг хэн болохыг нь тодруулах бичиг баримтгүй хэн нь мэдэгдэхгүй ийм хүнийг л зайлиггүй, магадгүй тэр хүн нь цаана нь эрэн сурвалжлагдаж байсан хүүхэд ер нь хүчиндсэн гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж байгаа этгээд байх ч юм билүү.

Тийм учраас цагдаагийн албаны нэр томъёо нь гэмт хэрэг зөрчил гэж нийтлэг арай өргөн утгаар томъёологдсон байгаа. Яг зөрчил шалгаж байгаа хууль нь болохоор зөвхөн нэг томъёолол л байгаа холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор гэсэн. Эдгээр хуулиуд нь хоорондоо бол яг бие биетэйгээ уялджихсан байгаа гэж ойлгож юу ойлгогдож байгаа. Түүнчлэн цагдаагийн байгууллагаас яг энэ хуулийн энэ заалттай холбогдуулаад бол тоон мэдээлэл үндсэндээ бол тийм өргөн байдаггүй. Эрүүгийн гэмт хэргийн шинжтэй гэдэг юм уу зөрчлийн шинжтэй бусад хууль,

тогтоомжуудтайгаа харьцуулахад жишээлбэл, 100-ны 99 хувь нь гэсэн үг л дээ. 100-ны 99 хувь нь зөрчлөөрөө эрүүгээрээ явна гэсэн үг. Жишээлбэл өнгөрсөн онд 97 хүн Цагдаагийн албаны тухай хуулийн 26.1.1-д зааснаар 6 цаг саатуулагдсан статистик мэдээлэл байгаа юм. Энэ он гарсаар 9 тохиолдол байгаа юм.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу? Нэмж тодруулах уу?

Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Тэгэхээр одоо саяын яг хэлсэн статистик бол яг анхаарал татаж байгаа байхгүй юу. 2023 онд яг Цагдаагийн хуулийн 26-гаар 99 хүн саатуулагдаж байсан бол энэ онд 9 хүн гэдэг чинь бусад саатуулагдсан хүмүүс Эрүүгийн процессын хуулиараа эсвэл Зөрчлийн тухай хуулиараа яг ингээд нөгөө тусгай журмынхаа дагуу ийм саатуулах ажиллагаа явагдаж байна. Тэрнээс биш улсын хэмжээнд 9 хүн саатуулагдаад тэр нь бүгдээрээ цагдаагийн хуулиар гэж би ойлгохгүй байна. Тэгэхээр ер нь бол яах вэ би цагдаагийн албаны хүмүүс байгаа учраас мэдээж бол бас энэ ажлын хэсэгт уг нь Хууль зүйн яамныхан бас орсон байлгүй дээ. Ороогүй байдаг уу? Эсвэл дан цагдаагийн байгууллага нь өөрөө ажлын хэсгээ байгуулаад ингээд авчихдаг юм уу. Тэгэхээр энэ дээр ажлын хэсэгт Хууль зүйн яамнаас 1 дүгээрт хүмүүс орсон уу?

Хоёрдугаарт яг энэ тоолох хугацаа хэзээ тоолох вэ гэдэг дээр л бид нарын гол анхаарал яваад байгаа шүү дээ. Тэгэхээр яг энэ түр саатуулах хугацааг тоолохдоо тухайн хүн өөрийн дураар үйлдэл хийх боломжгүй болсон тэр нөхцөлд тэр цаг хугацаанаас эхлээд тоолно гэдэг ийм томъёоллоор тоолох тодорхойлох боломж байхгүй юу гэж

асуух гээд байгаа гэсэн үг. Тэгээд энэ талаар бас ажлын хэсэг дээр я яригдсан байх тэ?

Д.Цогтбаатар: Ийм шүү. Энэ чинь нөгөө Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт орж ирж байгаа болохлоор энэ дээр ажлын хэсэг ч байхгүй. Манай Байнгын хороо өөрөө боловсруулаад оруулдаг байхгүй юу. Тийм журамтай. Би харин хаширлаад энэ холбогдох яг Цагдаагийн хууль энэ дээр хөндөгдөж байна шүү дээ. Тэгээд нэмээд энэ хүмүүсийг авчирсан байгаа юм. Түүнээс энэ дээр бол ажлын хэсэг угаасаа байхгүй. Та бид нар өөрсдөө энийгээ ингээд шууд нийцүүлээд л боловсруулаад л оруулдаг хуультай байхгүй юу. Тийм байгаа юм. Тэгээд холбогдох байгууллагуудаасаа бид нар саналууд юмаа аваад энэ Тамгын газар дээрээ хуульчидтайгаа зөвлөлдөөд энийг оруулж ирж байгаа шүү дээ.

Уянгахушиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахушиг: Энэ дээр нэг ийм асуудал байгаад байна. Ер нь бол 26.1, 26.2 гэдэг бол өөрөө түр саатуулах тухай яригдаад байдаг. Гэтэл түр саатуулах гэдэг маань онолын хувьд өөрөө тодорхой ойлголт байгаа. Томьёолол байгаа. Энийгээ түр саатуулах гэдгийг 26.2 дээр нэмж тодорхойлох гээд байгаа юм шиг ийм асуудал гарч ирж харагдаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол түр саатуулах гэдэг өөрөө угаасаа чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж байгаа тэр үйл явдал үйл явц. Гэтэл тэр үйл явцыг тодорхой нэг товч шийдвэр танилцуулснаар гэдэг юм уу, эсвэл эрх үүргийг нь танилцуулснаар гэдэг хүнээс шалтгаалсан тэр нэг үйлдлээс хамаараад тооцож эхлэх тухай асуудал яригдахаар энэ өөрөө буруу болчихоод л байна гэж хараад байна л даа. Тэгэхээр энэ дээр одоо жишээлэх юм бол

буцаагаад яг энэ томьёоллоор харахаар холбогдох эрх үүргийг тайлбарлаж өгсөн үеэс эхлэн тооцно гэж байгаа байхгүй юу.

Гэтэл нөгөө холбогдох эрх үүргийг нь түр саатуулах байрандаа аваачаад тайлбарлаад өгчихвөл яах вэ гэдэг нэг асуудал. Тэгэхээр нөгөө түр саатуулах байранд аваачиж эрх үүрэг тайлбарласан үеэс эхлээд нөгөө хугацаа чинь тоологдох юм уу гээд. Ер нь хууль өөрөө маш тодорхой үг үсгээр, салаа утгаар ойлгогдохгүй бай байж байх ёстой. Тэр утгаараа хэрвээ бид нар түр саатуулах гэдгийгээ томьёолох гээд байгаа юм бол эсвэл түр саатуулах гэдгийнхээ хугацааг тодорхойлох гээд байгаа юм бол нөгөө Үндсэн хуулийнхаа чөлөөтэй зорчих эрх гэдэгтэйгээ уяад явчихвал болохгүй юу гэдэг нэг тийм асуулт байгаад байна аа. Хэрвээ тэгэх юм бол бид нар заавал тэр түр саатуулахыг ямар нэгэн ийм дотор нь хийгдэж байгаа үйлдлүүд биш. Энэ одоо жишээлбэл холбогдох эрх үүргийг тайлбарлаж өгөх ёстой, шийдвэрийг танилцуулах ёстой гэдэг бол өөрөө түр саатуулах тохиолдолд тухайн хүнд Цагдаагийн байгууллагаас хийх ёстой чиг үүрэг.

Тэрнээс биш тэрийг хэзээ хийсэн бэ гэдгээс эхэлж тэр хүний түр саатуулагдаж байгаа хугацаа тооцогдоно гэдэг бол өөрөө дахиад л хүний эрхийн зөрчил нь цаанаа хадгалагдаад явчихна гэсэн үг. Тэгэхээр энэ дээр бол тэр чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлах гэдэг талаас бас оруулах боломж байх уу гэдэг асуулт санал хоёроо нэг дор л хэлчихлээ гэсэн үг.

Д.Цогтбаатар: Ийм шүү дээ Уянгахушиг гишүүн ээ. Та өөрөө хуульч хүн. Тэгээд энэ хуульд заасан процедур чинь хэлбэр юм шиг боловч аягүй цаанаа агуулгатай байхгүй юу. Би сая алх авчруулж байж хурал эхэлж байна.

Алхгүй хэдүүлээ хуралдаа явж болно шүү дээ тийм биз? Тэгтэл энэ заавал хийгдэх ёстой. Алга ташаад хийдэг ажил биш байхгүй юу. Процедур тэгж эхэлж байгаа. Тэгээгүй байхад би жишээлбэл одоо энэ жижигхэн процедурын юуг хийгээгүй байхад энэ хурал эхлээгүйд бид нар тооцно гэж та нарын хэн нь ч хэлэх эрхтэй байхгүй юу. Тэгээд энэ алхны тухай асуудал биш байхгүй юу. Төрийн албан хаагчдад үйлчилж байгаа хууль бол заавал биелүүлэгдэх ёстой. Биелүүлээгүй бол тэр хүнтэй нь хариуцлага тооцно. Хүн болгоныг 10 мянган цагдаа байгаа байх. Газар дээрээ яг ингэж хийгээд бид нар хуулиа л гаргаж өгч чадна. Энэ хүмүүс газар дээрээ яг тус хүн бүр биелүүлэх үү, үгүй юу гэдэг баталгааг та бид нарын хэн ч өгч чадахгүй, цагдаагийн дарга ч өгч чадахгүй. Тэрний баталгаа нь юу вэ гэвэл зөрччихсөн байвал тэр хүн баталгаатай хариуцлага хүлээнэ.

Тэгэхээр таны хэлж байгаагаар нэг заль гаргах гээд байна шүү дээ. Цагдаа хяналтдаа оруулчихсан. Тэгээд нөгөө миранда зарчим үйлчилж танилцуулахгүй би явсаар байгаад дараа нь тэр цагдаа шууд хариуцлага хүлээнэ шүү дээ. Амьдралд ийм юм гарч болно. Тэгэхдээ харин тэр хариуцлагагүй байсан бол таны яг хэлж байгаа бодит үнэн болчхож байгаа байхгүй юу. Цагдаа эргээд нөгөө хүн гомдлоо гаргана шүү дээ. Надаа энийг танилцуулаагүй юм аа. Тийм учраас би энэ дээр энэ машинд нь сууж байх үедээ би эрх чөлөөтэй байсан. Тэгэхэд танилцуулаагүй байхад машинаас нь тэр хүн өө уучлаарай тэгвэл би гараад явлаа гэхэд тэр хүнд хариуцлага тооцохгүй байхгүй юу. Би танилцуулчихаад машиндаа хийчихсэний дараа тэр хүн гараад явбал зугтсан. Наадах чинь ужсе өөрөө эрүүгийн хэрэг болж хувирч байгаа байхгүй юу. Тэгэхлээр тэр цагдаад миранда хамгийн түрүүнд танилцуулна гээд заачихсан

байгаа чинь амьдрал дээр тэгэхгүй байж магадгүй тэгвэл тэр хүн хариуцлага хүлээх эрсдэлээ даваад л тийм юм хийж байна гэсэн үг. Хууль ингэж л үйлчилж чадна. Түүнээс энд цагдаагийн хуулийн 22.2 дээр тэр миранда юу чинь хамгийн түрүүнд заавал хийгдэх ёстой юу байхгүй юу. Тэгж байж миний эрх зүйн статус өөрчлөгдөж тэр хүний эрх зүйн статус өөрчлөгдөж байгаа юм. Тэгээгүй байхад би бодитоор бариад байлгаад байж болно. Би хууль зөрчөөд байгаа байхгүй юу. Дараа нь би хариуцлага хүлээнэ. Нөгөө хүн тэрэнтэй холбогдсон хохирол гарах юм бол хохирлоо нэхэмжлэх эрхээ сэргээлгэх эрх нь нээлттэй байж байгаа байхгүй юу. Энэ тухай л юу яаж байгаа юм? Тэгэхлээр ажлын хэсэгт нэмж хариулах юм байна уу? Энэнтэй холбогдуулаад. 7 дугаар микрофон өгье.

П.Очбадрах: Очбадрах хариулж байна аа. Ер нь бол энэ түр саатуулах 6 цагийн асуудлыг гишүүд маань бас яг нэгдмэл нэгдсэн ойлголтгүй байна уу гэж. Өнөөдөр цагдаагийн байгууллага 2017 оноос хойш бол энэ түр саатуулах энэ процессын ажиллагааг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага дээрээ тухайн иргэнийг авчирч сануулж, тайлбарлаж хэлж байгаа эрх, үүргийг нь яг тусгаарлаад одоо бид нар нэг тусгайлсан бэлдсэн өрөө тасалгаанд тухайн иргэнийг саатуулахгүй байгаа. 2017 онд ХЭҮК-оос зөвлөмж өгсөн. Хүний эрхийг дээдлэхтэй холбоотойгоор цагдаагийн байгууллага бол тусгайлан бэлдсэн сараалжин хаалт төмөртэй өрөөнд энэ 6 цагаар иргэнийг саатуулахгүй болсон. Одоо яг практик дээр бол хүлээлгийн танхимд эргэн сууж байгаа тухайн конторын цагдаа нүдээр болоод хилийн хяналтын камераар хяналтаа тавиад бид нар энэ иргэнийг 6 цагийн хугацаатай саатуулж байгаа.

Нийслэл Улаанбаатар хотод бол яг гишүүдийн хэлээд байгаагаар яг энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотойгоор бид нар маш богино хугацаанд иргэний нэр хаягийг тодруулаад тухайн иргэнийг цагдаагийн байгууллагаас явуулах боломж бий. Түрүүн манай ажлын хэсгийн гишүүний хэлдгээр орон нутагт бол энэ яг хэрэгжихэд нэг мөр хэрэгжихэд маш их хүндрэл бэрхшээл тулгамдаж байгаа асуудал байна гэдгийг бас гишүүддээ ажлын хэсгийн зүгээс бас хэлээд ойлгуулах гээд бас хичээгээд байгаа юм. Энэ орон нутагт ялангуяа олноороо цугласан бүлэг бөөгнөрөл үүсгэсэн, иргэдэд айдас түгшүүр ингэж хуримтлуулж байгаа энэ иргэд дээр цагдаагийн байгууллага очно. Очсон хойноо энэ иргэнийг тухайн цагдаагийн байгууллагын мэдээллийн санд заавал шалгах шүүх шаардлага үүсэж байгаа. Бид нар энэ сүлжээ датагүй газар хэн болохыг нь тогтоох боломжгүй учраас хамгийн ойр сумын төв, хамгийн ойр баг, хамгийн ойр аймгийн төв рүү бид нар тээвэрлэж хүргэж байж энэ нэр хаягийг тодруулах шаардлага үүсэж байгаа.

Тийм учраас энэ Цагдаагийн албаны тухай хуулийн 26-гийн энэ заалт зохицуулалт цагдаагийн байгууллагад хэрэгтэй гэдгээ бас тайлбарлаж хэлж байна. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүн нэмэлт тодруулга өгөх цаг өгье.

Г.Уянгахишиг: Миний хэлсэн санаа болохоор гол нь энэ нөгөө 26.2 чинь өмнө нь байсан заалтыг нь бид нар санаж байгаа шүү дээ. Тэгэхээр одоо энэ нөгөө үндэслэл шалтгаан танилцуулах холбогдох эрх үүргийг тайлбарлаж өгөх маань өөр заалтууд дээр байгаа. Өөрөөр хэлбэл энэ угаасаа байх ёстой зүйл. Гол нь тэр хугацаа тоолох түр саатуулж байгаа хугацааг

тоолохдоо тухайн төрийн албан хаагчийн, цагдаагийн хийж байгаа үйлдлээсээ яг энэ тайлбарлах ёстой үүргээ биелүүлж байгаа хугацаанаас гээд уяад оруулаад ирэх нь хэр зөв юм бэ л гэж хэлээд байгаа юм. Тэгэхээр түр саатуулах гэдгийн яг гол цөм ойлголт нь юу юм бэ гэхээр чөлөөтэй зорчих эрх л байгаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол би өөрөө дураараа хөдөлж чадахгүй буюу би харилаа гээд явчхаж чадахгүй тэр нөхцөл байдалд орж байгаа тийм ээ тэгэхээр яг тэр чөлөөтэй зорчих эрхийг хязгаарласан үеэс эхэлж тэр түр саатуулах. Хэрвээ түр саатуулах гэдгийнхээ хугацааг тоолох нэг тийм моментыг хэлэх гээд байгаа юм бол тэрний чинь цаана тэр хүний чөлөөтэй зорчих эрх л хязгаарлагдаад байна шүү дээ л гэж хэлэх гээд байгаа санаа. Өөрөөр хэлэх юм бол буцаагаад 26.2-ын Үндсэн хуулийн цэц дээр Үндсэн хууль зөрчсөн байна гээд өөрчлөх шаардлага тавигдсан заалт нь өөрөө түр саатуулах хугацааг хэзээнээс тоолох вэ буюу түр саатуулах байранд авагдсанаас гэдэг юм байсан шүү дээ.

Тэгэхээр яг тэр агуулгаас нь харж буцаагаад яг үнэхээр түр саатуулах гэдэг утгыг илэрхийлэх гэж байгаа юм бол яг ямар эрх нь зөрчигдөж эхэлсэн үеэс юм бэ гэдэгтээ уявал зүгээр биш үү гэдэг санаа байсан шүү. Тэрнээс биш мэдээж яг энэ төрийн албан хаагчийн цагдаагийн хүлээсэн үүрэг байгаа. Байх ёстой. Тэрийгээр зөрчих юм бол хариуцлагаа хүлээх ёстой. Энэ нь бол цагдаагийн албаны хуульдаа бусад зүйл заалтаараа зохицуулагдаад явж байгаа гэж харж байгаа юм.

Д.Цогтбаатар: Яг үнэн. Тийм учраас энэ чинь аль нэг цэгээс л эхлэх гээд байна шүү дээ. Өөрийн чинь хэлж байгаагаар бол хэлэхгүйгээр ингээд барьчхад тэгээд дараа нь хэлснээс нь тооцно гэж бодоод байна шүү дээ. Тийм

биш шүү дээ. Яагаад гэвэл барьчихсан л бол тэр юу чинь өөрөө харин тэр хүн биш ээ хяналтдаа тэр хүн оруулчихлаа гээд цагдаа оруулсан байж болно тэгээд хэлээгүй байж болно. Тэгээд тооцохыг нь та дараа нь хэлбэл яах вэ гээд байна шүү дээ. Тэгтэл хэлэлгүйгээр хяначихсан байгаа чинь өөрөө хууль бус байхгүй юу. Тэр хүн яг эрх зүйн тэр дэвүүрийн нөхцөл байдал нь чөлөөтэй байгаа гэсэн үг. Та хэлэлгүйгээр барьсан. Одоо тэр миранда кэйс гэдэг чинь миранда тодорхой кэйс шүү дээ. Миранда гээд хүнтэй холбоотой кэйс байхгүй юу? Бүр тэрийгээ хэлэлгүй барьсны дараа тэр хүн шүүхээс чөлөөлөгдөөд гараад явсан байхгүй юу. Тэр чинь бүр хэчнээн дараа болж байгаа цагдаагийн үйл ажиллагааны хариуцлагагүй байдлаас үүслээ гээд. Тэгэхлээр энэ баривчлах юу гэдэг чинь төрийн үйл ажиллагаа орж аль нэг цагаас эхлэх гээд байна шүү дээ. Өөрөө бодитоор барьсан. Бодитоор барьчаад хэлэхгүй байгаад байгаа бол тэр барьсан барьсанд тооцогдохгүй байхгүй юу. Хэлээгүйгээр тэгсэн байгаа бол цагдаа хариуцлага хүлээх байхгүй юу. Түүнээс тэр хүн чөлөөтэй. Тэр хүн тэрэнтэй муудалцаад гараад явсан байхад цагдаагийн тавьсан хууль ёсны юу шаардлагыг биелүүлээгүй гэдэг хариуцлага тэр хүн дээр үүсэхгүй. Энэ тухай л яриад байгаа юм.

Тэмүүжин гишүүнд микрофон өгье.

Х.Тэмүүжин: Асуулт гэхээсээ илүүд нь бас хэд хэдэн сэдэв байна.

Нэгдүгээрт ҮХЦ-ээс гаргасан шийдвэртэй холбоотой түүний үр дагавартай холбоотой хэсгийг Хууль зүйн байнгын хороо бас дахиад нэг жоохон өргөжүүлж ойлгох ёстой байх. Үндсэн хуулийн цэц Цагдаагийн албаны тухай хуулийн нэг заалтыг энэ чинь иргэний үндсэн эрх, эрх чөлөө зөрчөөд байна, иргэний эрхийг хязгаарлаад байна

гэдэг байдлаар шийдвэр гаргаагүй. Зүгээр Цагдаагийн албаны тухай хууль дээр бичигдсэн ганцхан байгаа зүйл учраас тэрийг нь өлгөж аваад л иргэд гомдол гаргаад шийдвэр гаргасан. Яг адилхан энэ цагдаатай адилхан ШШГБ, АТГ, Хил хамгаалах байгууллага гэх мэтчилэн энэ байгууллагууд чинь бас яг ийм үйл ажиллагаа явуулж байгаа юм. Хууль дээр байхгүй, хуульгүй. Хуультай байгаа ганц байгууллага нь цагдаа байхгүй юу.

Цагдаагийн байгууллага энэ тухай хууль дээр бичигдсэн. Тэнд чинь бүүр ямар ч дүрэм журамгүй байгаа. Энийгээ яаж тоолдог нь ч байхгүй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага руу нэг эргэлтээр очиж байгаа хүн хууль зөрчөөд хоригдолд өгөх ёсгүй байгаа. Утас дамжуулчхаж байгаа байхгүй юу. Тэгээд зөрчил гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийчхэж байгаа юм. Тэгээд тэрэнтэй холбоотой асуудлыг нь ямар хуулиар, ямар дүрэм журмаар үзлэг нэгжлэг хийж байгаа юм. Баривчилж эрхийг нь хязгаарлаж байгаа юм саатуулж байгаа юм. Тийм юм юу ч байхгүй. Гааль дээр мөн адилхан.

Гаалиар бараа бүтээгдэхүүн оруулж ирж байгаа. Магадгүй хар тамхи, эс үгүй бол юу гэдэг юм хууль бус юм ороод ирдэг. Гаалийн албан тушаалтан үзлэг нэгжлэг хийж байгаад нөгөө хүнээ саатуулах хэрэг гарна. Хэзээнээс нь эргэж саатуулсан гэж үзэж байгаа юм гэх мэтчилэн. Энэ чинь өөрөө эрх зүйн хувьд ингээд маш ойлгомжгүй байна нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь ингээд зөвхөн цагдаагийн албаны хууль дээр бичсэн ийм агуулгаар хэрэглэж байгаа бол энэ чинь учир дутагдалтай байна гэсэн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэц гаргасан чинь бид нар буцаад Цагдаагийн тухай

хууль дээр ноцолдож байгаа юм, нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь яг энэ хуулийг өмчлөөд авсан юм шиг ажлын хэсэг дээр цагдаагийн албан хаагчдаа оруулж ирээд ажлын хэсэг гээд энэ хүмүүсээс асуугаад байгаа байхгүй юу. Энэ чинь Хууль зүйн байнгын хороо бараг Хууль зүйн яамных нь мэргэжилтэн орж ирээд тайлбар хийж байх ёстой тэр хэмжээний бодлого байх ёстой байхгүй юу. Би нэг зүйл дээр бас жоохон гайхаад болгоомжлоод байна. Ер нь процессинг хийдэг хэрэгжүүлэгч байгууллагыг хуулийн төсөл боловсруулах байдлаар оруулж ирдэг энэ арга барилаасаа хэдүүлээ салах ёстой. Тэр байгууллага өөрийнхөө ажлыг хөнгөвчлөх нүдээр л асуудлыг харна. Хөндлөнгийн шинжээчийн, хөндлөнгийн байр сууриас харахгүй шүү дээ. Тийм учраас энэ боловсруулалт дээр ажлын хэсэг гээд 2 цагдаагийн албан хаагч энд сууж байна. Парламент яг ийм ийм хэлбэрээр ажиллаж ерөөсөө болохгүй. Хөндлөнгийн хэсэг чинь хаана байх юм? Яг энэ чиглэлээр ажилладаг өмгөөлөгч нар энэ дээр орж ирж байгаа юм уу? Санал нь орж ирсэн үү?

Д.Цогтбаатар: Би түрүүн Баасанжаргал гишүүний юунд тайлбарласан. Энэ чинь нөгөө тусгай процедураар манай Байнгын хороо бид нар гаргаад байхгүй юу. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн дагуу энэ өөрчлөх энэ манай Байнгын хороо өөрөө санаачлаад өргөн барих ёстой. Би тэгэхлээр нь хаширлаад зүгээр бас амьдрал дээр яагаад гэвэл Сайнзориг гишүүн ч ярьж байсан, цагдаагийнхан ч бас хүндрэл бий шүү гэхлээр эд нарыг сонсолгүйгээр бид харин өөрсдийнхөөрөө хийчхээд, гэхдээ миний сая протоколд хэлээд байгаа нь та нарын ажилд хүндрэл учруулах юм яг амьдрал дээрээ гарчхаж байгаа бол тэгвэл энийгээ та нар нэмж боловсруулаарай энэ эрх чинь нээлттэй

шүү гээд хэлчихсэн. Энэ чинь тэгээд анхны хэлэлцүүлэг. Одоо энэ дээр санал байгаа бол Сайнзориг гишүүн ч, Тэмүүжин гишүүн ч саналаа өгөх эрх байж байгаа шүү дээ. Яагаад гэвэл энийг бид л хийж байгаа юм. Нэг юу та нар маань нэг юм бодоорой. Энэ саатуулах ажиллагаа бол байна шүү дээ. Манайх 6 цаг гэдэг чинь бүүр тэгж яривал бид нар ёстой л Сайнзориг гишүүн эд нарын яриад байгаагаар амьдралыг тооцож 6 цагаар тавьж байгаа болохоос биш зарим оронд байна шүү дээ Солонгост 30 минут. Хүнийг тэгж халдах асуудал чинь аягүй хуулиараа хатуу хамгаалалттай байхгүй юу. Японд 15-аас 30 минут, Германд 30 минут байна шүү дээ.

Тэгэхээр энийгээ бид нар бас нэг тооцож юу яана биз. Энэ боломж бүгдээрэнд нь нээлттэй байгаа шүү. Тэмүүжин гишүүнд микрофон өгье.

Х.Тэмүүжин: Тийм учраас нөгөө ажлын хэсэг гэдэг юм уу эс үгүй бол энэ нөгөө дэг өөрөө нэг тийм жоохон ойлгомжгүй яваад байна.

Хоёрт нь гишүүдийн асууж байгаа асуулт юун дээрээс бид нар дахиад нөгөө Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй холбогдуулаад Хууль зүйн байнгын хорооны хувьд бас дахиад нэг юм харах ёстой юм нь юу вэ гэхээр нөхцөл байдал өөрчлөгдөж байна аа. Жишээ нь одоо ингээд ийм нөхцөл байдал гардаг аа. Жишээ нь энэ текст дээр байгаагаар сануулсан чинь зугтчихвал яах вэ? Зугтчихвал энэ асуудал биш байхгүй юу. Цагдаагийн байгууллага юм уу, эс үгүй бол хууль сахиулах байгууллагын бие бүрэлдэхүүн чинь хойноос нь хөөгөөд гүйцэх хэмжээний бие бялдартай хүнтэй байгаа юм уу? Яг энийгээ баривчлах үйл ажиллагаа хийхдээ ингээд тодорхой стандарт байгаа юм уу? Зүгээр гудамжинд жирийн иргэн жирийн

иргэнтэйгээ харьцаж байгаа юм шиг үг хэлээд нөгөөдөх нь зугтаад явчхаж байгаа юм шиг юм болж байгаа бол мэргэжлийн байж чадаж байгаа юм уу гэх мэтчилэн өөр асуудал байхгүй юу. Энэ иргэний эрхийг хязгаарлах үндэслэл ерөөсөө биш. Иргэний эрхийг хязгаарлаж байгаа тэр байгууллага чинь тоног төхөөрөмжийн хувьд зохион байгуулалтын хувьд, боловсон хүчний хувьд учир дутагдалтай байна. Бэлтгэл хангагдаагүй байна. Хөрөнгө санхүү байхгүй байна гэж байгаа бол тэр нь тусдаа асуудал. Тэрийгээ тусад нь шийдэх ёстой. Тэр бэлтгэгдээгүй учраас одоохондоо иргэнийхээ эрхийг зөрчье гэдэг ийм логик ерөөсөө байж болохгүй л гэдэг зарчим. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр дээр өөрөө тусгагдаж байгаа. Энэ зарчмыг энэ логикийг нь ойлгоод энийг энэ хуулийг сайжруулъя гэж Хууль зүйн байнгын хороо ярьж байгаа гэдэг өнцгөөсөө харахгүй бол одоо ийм нөхцөл байдал байгаа гэдэг нөхцөл байдлаа ярьсаар байгаад энэ нөхцөл байдлаасаа болоод хүний эрхээ одоохондоо зөрчөөд явж байя гэдэг ийм дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороон дээр бас яримааргүй байна гэдгийг л би хэлэх гэсэн юм.

Д.Цогтбаатар: Энэ дээр би зүгээр ажлын хэсэг гээд энэ яриад байгаа нь ажлын хэсэг биш шүү хөөе. Бид нар өөрсдөө урьж авчраад юу яаж байгаа юм. Түүнээс энийг бид нар хэлэлцэж байгаа юм хэдүүлээ. Тэгэхээр энэ дээр оруулах санаа эд нар байгаа бол манай гишүүдэд энэ чинь анхны хэлэлцүүлэг яг л хуулийнхаа процедураар явж байгаа нээлттэй байж байгаа Тэмүүжин гишүүний саяын яг ярьж байгаатай санал нэг байгаа шүү. Үндсэн хуулийн цэц яг ингэж бид нар тэгэхлээр сайжруулах талдаа л гаргаж өгөх ёстой. Сайжруулах талдаа л гаргаж өгөх ёстой. Тэгээд энэн дээр бол өнөөдөр тэр байж байгаа одоо хүчин төгөлдөр тэр нөгөө Үндсэн хуулийн

цэцийн гаргасан шийдвэр чинь Тэмүүжин гишүүнээ гааль бусад нөгөө хил гээд ингээд ярих гэхлээр гомдол чинь яг Цагдаагийн хууль дээр л гараад л энэ дээрээ л дүгнэлт орж ирсэн байхгүй юу. Харин тийм тийм. Тэгэхээр нөгөө бусад юмнууд дээр нь ёстой хэдүүлээ хуулийг гүйцээгээд боловсруулаад яриад явж болно шүү дээ, энэ нээлттэй. Тэгэхгүй бол энэдээ орж ирээгүй юмыг би ярьж чадахгүй л байгаад байна л даа.

Ингээд оролцож байгаа экспертүүдэд хэлэх санал байна уу? Энэнтэй холбогдуулж. 6 дугаар микрофон өгье.

Б.Батзориг: Гишүүддээ гишүүддээ санал танилцуулахад Монголын нөхцөл байдал сая Цогтбаатар даргын хэлснээр бол одоо Солонгост тэдэн цаг, Японд тэдэн цаг, Америкт нэг цаг гэх мэтчилэн Германд бас цаг байдаг ийм байдаг юм байна гэж байна. Яг Монголын нөхцөл байдал маань өөрөө тархай бутархай, 21 аймаг, 333 сум бидний түрүүний хэлээд байдаг нийслэл, төв суурин газар, аймгийн төвд асуудал байхгүй. Хамгийн гол нь энэ тархай бутархай уул, гуу жалганд байгаа хэн нь болох нь тогтоогдохгүй хэн нэгэн этгээд олдлоо гэхэд түүнийг хэн бэ гэдгийг тодруулахад л цаг хугацаа шаардлагатай байгаа юм. Ийм учраас санал хэлэхэд нийслэлийн хэмжээнд тодорхой цагийг тоолоход асуудал байхгүй. Хөдөө орон нутаг алслагдсан зайд тухайн этгээдийг магадгүй 200, 300 км явж байж аймгийн төв дээрээ очиж байж шалгах төхөөрөмжтэй боломжтой болох ийм нөхцөл байдлыг бас харгалзан үзээрэй гэсэн саналыг илтгэж байна. Танилцуулж дууслаа.

Д.Цогтбаатар: Зөв зөв. Яг тэр үүднээс би та бүгдэд давтаад хэлэхэд та бүгд энд суух ч уг нь юугүй байна шүү дээ, статусгүй. Би тэгээд суулгаад

яриулаад байгаа чинь та нарыг энийгээ бас гишүүдэд хэлээсэй, өшөө тэгээд энэ дээр нэмж боловсруулах юмнуудаа бол нэмээд боловсруулаад оруулаад гишүүд санаачлаад орж ирэх боломж чинь нээлттэй шүү л гэж хэлж байгаа шүү. Тэгээд тэр бол аль аль гишүүдэд бас энийгээ бодолцох байх аа. Ингээд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Нарантуяа гишүүнээр, Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгэхээр яах вэ Үндсэн хуулийн цэцийн гаргасан шийдвэрийн дагуу сайжруулах процесс л явах ёстой болохоос биш дордуулах ухрах зүйл байж болохгүй ээ.

Хоёрдугаарт яах вэ зүгээр нэг зүйл байгаа. Цагдаагийн албаны хуулийн яг энэ нөхцөл байдлаар юу хийдэг вэ гэхээр яг хэн болох нь тухайн үед тод тодорхойгүй этгээдийг шалгаж мэдээллийг нягталсны дараа зөрчлийн процесс эхлэх үед Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай процессоор явах уу гэдэг энэ шийдлийн дунд байж байгаа. Зааг уулзвар нь 26.2 байгаа юм. Бид хэд гаалиар ч юм уу, хилээр орж ирж байгаа эсвэл тэр шүүхийн шийдвэр байгууллага дээр орж байхаар тэр зөрчлийг гаргаж байгаа этгээд чинь хэн бэ гэдэг нь мэдээлэл нь байж байдаг байхгүй юу. Тэгэхээр энэ процесс заримдаа явахгүй байх талтай. Хэрэвзээ тэр Тэмүүжин гишүүний яг жишээ авч байгаа тэр утас дамжуулж байгаа бол тэр чинь шууд зөрчлийн юм уу, эрүүгийн процессоороо тухайн мөч дээр л явах боломжтой байхгүй юу. Хэн бэ гэдэг нь ойлгомжтой. Яг энэ чинь нөгөө тодорхой хэн гэдэг нь ойлгомжгүй эсвэл нэрээ буруу хэлээд байгаа. Хил орчим дээр гадаадын иргэн үү, Монгол Улсын

иргэн үү гэдгийг нягталж шалгаад аль хуулиараа явах вэ гэдэг энэ процесс дээр б цаг хүртэл саатуулах бололцоо зүгээр байж байгаа. Энийг хэзээнээс тоолох вэ гэдгийг зөвхөн танилцуулснаар гэвэл яг түрүүн Уянгахишиг гишүүний хэлж байгаа шийдлүүд гарна практик дээр.

Тийм учраас бид хэд дордуулах гээд байна. Энийгээ харин танилцуулснаар гэдэг дээр нь нэмээд тэр юу гэдэг юм зорчих гэдэг юм уу чөлөөтэй зорчих эрхийг нь хязгаарлаж байгаа тэр үйлдэл болгоныг бид хэд агуулгын хувьд оруулж өгч байж бүрэн болох байхгүй юу. Бид хэд тэр үйлдлүүдээс нь харин саатуулах байранд байсан гэдэг агуулгыг нь бүүр авч хаянгуутаа бүүр наад тал дээр нь бүүр дордуулаад хаячхаж байгаа юм. Тэгэхээр энэ хууль хэрэглээний явцад нугалаа гарна.

Хоёрдугаарт яг энэ хэсэг дээр түрүүн бие бялдрын хувьд муу ч гэдэг юм уу ийм цагдаагийн албан хаагчийн асуудал гэж байгаа. Магадгүй гүйгээд алга болчхож болно. Тэр бол нэг бие бялдартай холбоотой ч биш. Яг энэ тохиолдолд тэр хүний хувийн хэрэг дээр эрх үүргийг нь танилцуулж дууссан байсан гэдгээрээ саатуулагдаж байсан гэдэг ийм хувийн хэрэг үлдэх юм уу эсвэл энэ саатуулагдсан процесс зогссон буюу дараа нь энэ үйл ажиллагаа эхлээгүй гэдэг зүйлийг жишээ нь яг энэ хүнтэй холбоотойгоор Цагдаагийн албаны хуулийн 26 дугаар зүйл дээр бичиж өгөх ёстой шүү дээ. Тэрнээс биш тэр чинь ингээд зогсчхож байгаа байхгүй юу гээд амаараа бид нар энд хуулийг ингэж хэлж болохгүй шүү дээ хүний эрхийн энэ зорчих хөдөлгөөн. Тэгэхээр ийм зүйлүүдийг нь тодруулах зайлигүй юм байх шиг байна аа.

Тэгэхээр би Цогтбаатар даргаас өнөөдөртөө энийгээ ер нь буцаагаад бас гишүүд, Тэмүүжин гишүүн байдаг юм уу

манай өмгөөлөгчөөр ажиллаж байсан олон гишүүд байх шиг байна. Энийгээ бас нэг хэлж яриад тэгээд гол нь бас Хууль зүй, дотоод хэргийн яам байр сууриа нэгтгэнэ. Хууль зүй, дотоод хэргийн яам л хөндлөн байхыг хичээдэг байхгүй юу. Өмгөөлөгчдөө сонсоно, шүүгчдээ сонсоно, прокуророо сонсоно, мөрдөгчдөө сонсож байж нэг баланслаад нэг иймэрхүү зохицуулалт оруулчихвал болох юм байна гэж л орж ирдэг. Тэгэхээр бид нар энэ институцээсээ асуухгүйгээр зөвхөн нэг оролцогч байгууллагаа яачхаад одоо энэ дээр прокурорууд жишээ нь өөр юм ярина. Тэгэхээр энийг бас анхааралдаа авч нэг заалтын цаана жижиг агуулга ярих гээд байгаа юм шиг мөртөө би тэгээд сайжруулж байна гээд байгаа боловч миний зүгээр итгэл үнэмшилээр энэ бүүр улам ингээд ухраад хий нугалаад гарахаар боллоо гэдэг зүйлийг л хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Тэмүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүжин: Сайнзориг гишүүний энэ өөрөө нөгөө хүний нэр хаягийг тодруулах гэдэг ганцхан үндэслэл биш. Гэмт хэрэг зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох гэж байгаа байхгүй юу. Энэ чинь өөрөө нөхцөл нь өргөн байхгүй юу. Зүгээр бид нар нэг зүйлийг жсоохон дутуу хараад байгаа юм. Ер нь Цагдаагийн албаны тухай хууль дээр энэ заалт байх ёстой юу үгүй юу гэдгийг бид нар дахиад нэг ул суурьтай харах ёстой. Түрүүн Уянгахишиг гишүүн, Баасанжаргал гишүүний үгэн дотор гарав уу даа. Бусад улс оронд чинь law inforce акт гэж гаргаж байгаад аль байгууллага хийхээс үл шалтгаалаад нэг стандартаар иргэний эрхийг хязгаарладаг, иргэний эрх рүү халдаг тэр журам тогтоож өгч байгаа. Тэр нь гаалийн байгууллага байна уу, Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх байгууллага байна уу, цагдаагийн байгууллага байна уу, татварын цагдаа байна уу, эс үгүй бол шүүхийн цагдаа байна уу? Эс үгүй бол АТГ байна уу хэн байхаас үл шалтгаалаад үнэхээр иргэний бие, эд зүйлд үзлэг хийж байгаа бол дотогш нь нэвтэрч нэгжлэг хийж байгаа бол ямар нэгэн хязгаарлалт тогтоож байгаа бол эд хөрөнгийг нь хурааж авч байгаа бол нэг стандартаар халдахыг л зөвшөөрч байгаа байхгүй юу.

Цагдаагийн байгууллага нь нэг хуультай, нөгөөдүүл нь огт хуульгүй. Даргын гаргасан журмаар явдаг Монгол шиг ийм хуульгүй улс байж болохгүй шүү дээ. Манайд rule of law гэдэг тогтолцоо бүүр байхгүй болчихсоны хамгийн тод жишээ энэ. Тэгэхээр бид энэ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг далимдуулаад Хууль зүйн байнгын хороо жсоохон мэргэжлээрээ ажиллаад 3 ажилд жсоохон чиглэл өгөөсэй гэж хүсэж байгаа юм.

Нэгдүгээрт нь Хууль зүйн яам руу, Хууль зүй, дотоод хэргийн яам руу энэ иргэний Үндсэн хууль дээр байгаа шүү дээ. Үндсэн хуульд иргэний үндсэн эрх эрх чөлөөг зөвхөн хуульд заасан үндсэн журмаар хязгаарлана гэж байгаа юм. Гэтэл маш олон байгууллага хуульд заагаагүй даргын гаргасан журам, ерөнхий прокурорын, тагнуулын байгууллагын гаргасан журам гэх мэтчилэн тийм журмаар хязгаарлаад сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ засаад одоо хууль сахиулах үйл ажиллагааныхаа хуулийг оруулж ир ээ. Энэ хуулиараа энэ түр саатуулах нэгжих эд хөрөнгө битүүмжлэх, хураах гэх мэтчилэн энэ зүйлүүдээ нэг стандарттай болгож ав гэдэг шаардлагыг нь тавиад нэг талаасаа ажлаа жсоохон томоор хараад явуулах ёстой байх.

Хоёрдугаарт нь Цагдаагийн албаны хуулийн энэ хэсгийг хүчингүй болгочихсон. Энэ хүчингүй болгочихсон энэ хэсгийг хараад хэдүүлээ ер нь Цагдаагийн байгууллагын тухай хууль дээр ийм заалт байгаа юм уу? Байх ёстой юм уу? Ер нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэх мэтчилэн нөгөө байгууллагууд дээр чинь одоо энэтэй ижил хэмжээний заалтууд байгаа юм уу? Байхгүй юм уу? Тэрэн дээрээ нэг мэдээллээ нэгтгэх 1 ажил зохион байгуулах хэрэгтэй юм шиг байна. Яг одоо эхний удаа энэ тоо тоолохтой холбоотой энэ хэсэг чинь үнэхээр хэцүү байгаа бол түр зуурын зохицуулалтаа хийхийн тулд яаж хийх юм бэ? Яг энэ хэлбэрээр хийж болж байна уу үгүй юу гэдэг дээрээ дахиад нэг нухацтай суумаар санагдаж байна. Сайнзоригийн хэлээд байгаа бол нэг үнэн. Тэр юу вэ гэхээр зөвхөн ингээд мэдэгдсэнээр биш хэд хэдэн зүйлээр энэ тоог тоолдог эхний факт, эхний тэр нэг цэг чинь явдаг жишиг байгаад байгаа байхгүй юу улс орнуудад, мэдэгдэж байна. Мэдээж хэрэг мирандагийн зарчим үйлчлэх ёстой. Машиндаа авч хийснээр, гав зүүснээр зүгээр ингээд дуудаж ирүүлээд байгууллага дээрээ сууж байгаад тантай холбоотой энэ яг энэ асуудал дээр бид нар арай өөр дэглэм хийхээс өөр арга байхгүй байна. Таныг бид түр саатуулж байна гээд байгууллага дээр урьж авчирч байгаа байгууллага дээр барьж болно. Машинд хийж болно, машинд байхгүй газар энд байж байг гэнгүүт нөгөө арай ч нөгөө шонгийн модноос гавладаг шиг байж болохгүй байх. Гэхдээ гудамжинд ч гэсэн түр саатуулж болно шүү дээ. Дахиад ийм нөхцөл байдал үүсэж байгаа байхгүй юу. Эмх замбараагүй байдал үүсгээд юм уу эс үгүй бол жагсаал цуглааны үеэр Германы тэр хамгийн түгээмэл хэрэглэдэг автобус руу ачаад хотын гадаа аваачаад хаячхаж байгаа байхгүй юу. Тэгэхэд автобус руу ачиж байгаа хэсэг дотроо энэ түр саатуулах

гэдэг чинь хэрэглэгдэж байгаа байхгүй юу.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофон өгье.

Энэ бол 2 талтай асуудал л гэж ойлгож байна. Тэгээд яг ямар цаг үеэс тэр хүний эрхийг хязгаарлах нь эхлэх юм гэдгийг нарийн гаргах хэрэгтэй. Ер нь тэр эрхийг нь хязгаарлаад эхэлснээс л хойш тэр эрхийг хязгаарласан тэр байгууллага л тэр хүний амь нас, эрүүл мэнд бүх юмыг л хариуцна шүү дээ. Үр дагавар нь ноцтой. Хөдөө орон нутагт бол ерөөсөө л нэг хэсгийн цагдаа 1 офицер 2 л байдаг шүү дээ. Тэгээд амьдралын нөхцөл байдал их ган, зуд болдог. Энэний дараа малгүй болсон иргэд мэдээжийн хэрэг тэр саяын яриад байдаг нөгөө байгаль руугаа орж тэрнээс үр шимийг нь авах гэж явдаг. Тэр нь янз бүр байдаг ийм зүйлүүд байдаг л даа. Хэдэн 100 км-ийн алсад. Тэгээд холбоо, харилцаа байхгүй. Нөгөө цагдаа нар нь бол унаа малгүй бензин тосгүй амьдрал бол ийм л байдаг. Тэгэхээр тэр нөхцөл байдлыг яг сум, суурин газар юм уу Улаанбаатар хот дээр байгаа нөхцөлтэй харьцуулж болохгүй ээ. Яг тийм үед ямар байх вэ гэдгийг нь бас энэ хуульдаа зааж өгөх ёстой. Тэгээд боломжийг нь хангах ёстой бол тэр тоног төхөөрөмж, техникээр нь бол тэр старлинк энэ тэр гээд бий болчихлоо шүү дээ. Тэр мэрийг нь хангачих боломжтой газар. Тийм үед нь яаралтай хангадаг барьдаг ийм юмыг бас оруулж өгөх хэрэгтэй. Хэрэв тоног төхөөрөмж тэр юмыг нь ажиллах нөхцөлийг нь бүрдүүлж өгч чадаагүй бол бас тэр цагдаагийн албан хаагчийг буруутгаад байж болохгүй ээ. Нөгөө манай цагдаагийн албан хаагчдын нэр хүнд бол асар их унаж байна л даа. Манай дарга нар, сайд нар гарч ирээд л энэ хулгайч, тэр хулгайч гээд зарладаг. Тэгээд тэрнийхээ дагуу арга хэмжээ авдаггүй. Нөгөө иргэдэд болохоор маш

ширүүн хатуу хандаж байна гэсэн зүйл явж байдаг. Тэгээд тэр эмнэлгийн орон дээр 21 настай залуу гавтайгаа нас барж байх жишээтэй. Тэгээд ийм шаардлагатай нөхцөл байдалд бас тухайн орон нутгийн засаг захиргаа нь тусламж дэмжлэг үзүүлдэг тийм хуулийн зүйл заалт байгаа байх л даа. Тэр зүйл заалтыг бас өөр нарийсгаж бас боломж бололцоог нь хангасан ийм нөхцөл байдлыг оруулж өгөх нь зөв байх аа. Бас юм болгон дээр л тэр нэг орон тоо нь ч гүйцэд ажиллахгүй байгаа. Яг хөдөө орон нутагт байгаа хэсгийн тэр цагдаа нараа бас буруутгаад байж болохгүй. Энэ зүйл заалтыг оруулсан ийм амьдралтай хууль л хийхгүй л бол эндээс одоо бид нар яг тэр Европт ямар байдаг вэ тэнд тийм байдаг гээд тэрний жишгээр хийчихээр бүр баларч байна шүү дээ. Тэр энэ Европ Европ биш болсон байна. Тэр цагаачдынхаа өмнөөс бол ямар ч юу хэрэглэж чадахгүй ийм байдалтай байна. Тэгээд 2 талтай зүйл шүү гэдгийг бас тэр ажлын хэсэгт ажиллаж байгаа гишүүд бас анхааруулаад хэлчихье ээ. Энэ дээрээ анхаарч ажиллаарай. Мэдээж хэрэг энэ зүйлийг бол тогтолцоогоор нь өөрчлөх сайн судалгаан дээр ажиллах ийм шаардлага байна шүү. Нэг их л олон ажлын хэсэг гаргаад байгаа. Яг шаардлагатай ийм юман дээр бид нар анхаарч ажиллах ёстой байхгүй юу.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Цагдаагийн албаны тухай хуулийн 22.2-ыг бид нар давхар харах ёстой юм шиг байна. 22.2 дээр сая тэр нөгөө мирандагийн зарчим гээд хүнийг саатуулсан хүний эрхийг хязгаарласан үедээ мэдэгдэнэ ээ гэдэг заалт 22.2 дээр байна. Гэхдээ 22.2 дээрээ даруй гэдэг юм байхгүй байна гэдгийг 1 дүгээрт хараад тэгээд 26.2 дээр оруулахдаа саатуулах шийдвэр гарсан даруй эсвэл яг нөгөө цагдаагийн

байгууллагын хяналтад орсон цаг үеэс эхлэн энэ хугацааг тоолно гэдэг ийм томъёололтой байх саналтай байна.

Тэгээд 2 дугаарт яг зарчмын дагуу ер нь энэ хүнийг албадан саатуулах, саатуулах, эд хөрөнгийг нь саатуулах энэ үйл ажиллагаануудыг ингэж тус тусын байгууллагын тухай хуулиар зохицуулаад байгааг ер нь бид нар эргэж харах ёстой энэ парламент ялангуяа. Сая тэр хэлж байсан Гаалийн байгууллагын тухай хууль дээр жишээ нь 251 дээр бараа тээврийн хэрэгслийг саатуулах журмыг Гаалийн удирдах төв байгууллагын дарга батална гэж байгаа байхгүй юу. Дахиад нөгөө хуулиараа байхгүй гэдэг жишээ чинь л ерөөсөө л яг энэ гэсэн үг тэ? Гаалийн тухай хуулиараа гаалийн байгууллагын даргын баталсан журмаар саатуулах журмыг батална гээд. Тэгэхээр яг ийм стандартаар яваад байгаа чинь өөрөө бид нар хүний эрхийн зөрчил гээд байгаа чинь ерөөсөө энийг л хэлээд байгаа юм. Яг энэ зөрчил, процесс, эрүү гэдэг яг энэ процессын энэ журмаараа энэ хүний эрхийг хязгаарлаж байгаа энэ заалтуудаа нэг мөр зохицуулах ийм хэрэгцээ шаардлага байна аа.

Тийм учраас Цагдаагийн байгууллагын тухай хууль дээр байгаа энэ 26, 27 гээд их олон ийм заалтууд байгаа. Энийг ер нь бид нар цаашид эргэж харах ёстой гэсэн ийм саналтай байна.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүнд микрофон өгье.

М.Номинчимэг: Баярлалаа. Тэгэхээр өнөөдөр яах вэ ингээд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр хүлээж авсантай холбогдуулж 26.2 дээр энэ саналын томъёолол орж ирсэн. Тэгэхээр энийг сая бас энэ гишүүдийн хэлэлцүүлэг дунд ч гарлаа. Бид нар энэ 2 юмыг холиод томъёолчихсон байгаа учраас бас

дэмжих боломжгүй байна гэж үзэж байгаа юм. Яах вэ энэ мирандагийн зарчим буюу эрх үүргийг нь тайлбарлах энэ асуудал бол ерөөсөө хугацаа тоолох эхлэл болдоггүй. Гаднын туршилагаараа ч гэсэн. Энэ бол өөрөө тухайн процесс хүчин төгөлдөр болсон уу, үгүй юу гэдгийг нь л нөгөө процессын зөв явсан уу гэдгийн шалгуур нөхцөл болдог. Өөрөөр хэлбэл хэрвээ түр саатуулаад мирандад эрхийг нь тайлбарлахгүйгээр тухайн түр саатуулах байранд байдаг, ямар нэгэн байдлаар мэдүүлэг авсан тогтоосон нь яах юм бол? Хэрвээ тэр нь дараа нь процессын явцад хүний эрхийг хангаагүй гэдэг үүднээсээ нотлох баримтын шаардлага хангахгүй л гэсэн үг. Тэрнээс тэр хүн түр саатуулагдсан уу саатуулагдсан. Түр саатуулах гэдэг маань өөрөө ерөөсөө л өөрийн дураараа хөдөлж өөрийн дураараа зорчиж явах энэ эрхийг нь л хязгаарлаж байгаа юм.

Тэгэхээр хугацаа тоолох асуудал бол мэдээж тухайн хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж байгаа буюу өөрийн дураар хөдлөх боломжгүй байгаа тэр үеэс тооцогдох ёстой. Миранда эрхийг нь тайлбарлах асуудал бол энэ процесс өөрөө процессын хувьд хүчин төгөлдөр болж байна уу, үгүй юу гэдгийг л хангах нэг шалгуур буюу хүний эрхийг хангах энэ шалгуур нь байхгүй юу. Тэгэхээр энийг бол холиод ерөөсөө миранда зарчим тайлбарласнаас хугацааг нь тооцно гээд орохоор одоогийн энэ яваад байгаа хэлэлцүүлэг бодоод байгаа юм аа. Тэгэхээр энийг ялгаж салгаад яг энэ нөгөө гишүүдийн хэлж байгаа шиг тухайн иргэн өөрийн дураараа хөдөлж зорчих боломжгүй үеэс л ер нь бол тэрийг нь тоолох нь зүйтэй. Энэ тоолоод энэ хийсэн процесс хүчин төгөлдөр хууль ёсны байсан уу, үгүй юу гэдэг дээр тэр эрх үүргийг нь тайлбарлаж өгсөн үү, үгүй юу гэдэг асуудал орох ёстой юм.

Тэгэхээр энэ дээр гишүүдийнхээ саналыг ч нэлээн бас сонслоо. Энийг бас дахин илүү сайн боловсруулаад илүү өргөн хүрээнд нь харах юм уу эсвэл яг яаралтай энэ хугацаа тоолох асуудал тулгамдаж байна гэх юм бол энэ чиглэл рүү нь найруулгын томъёоллыг нь өөрчилж оруулах саналтай байна.

Д.Цогтбаатар: Нарантуяа гишүүн.

М.Нарантуяа-Нара: Сайн байцаана уу бүгдээрэнд нь мэнд хүргэе ээ. Миний бодлоор ингэж бодлоо л доо жишигээр манайх гадаадын ийм жишигийг бас авч байна, дотооддоо яг энэ хуулиараа байхаар бас хөдөө орон нутаг бүсээс шалтгаалаад асуудлууд үүсдэг гээд тэгж байна л даа. Тэгээд дээрээс нь энэ асуудалтай холбоотой түр саатуулахтай холбоотой байгууллагын албаны тус тусын ийм хууль заалтууд байдаг гээд. Тэгэхээр миний бодлоор энэ аль аль нөхцөл байдлыг нь харгалзаж үзээд ерөнхийдөө нэг ийм уян хатан тэгсэн мөртөө одоо жишигээр шууд тодорхойлох боломжтой арга хэмжээ авах боломжтой энэ бүсүүддээ цагийг нь багасгаж өгөөд тэгээд нөгөө хөдөө орон нутагт шууд тогтоогоод ийм асуудалтай зүйлүүд байна гэж байна шүү дээ. Тэгэхээр тэр юунууд дээрээ энэ б цаг гэдгээрээ тогтоод ингээд явбал яадаг юм болоо гэсэн ийм бодолтой байна. Тэгээд энэ талаар бас миний хувьд бас ингэж бодож байна. Үнэхээр нөгөө бас мэдэхгүй асуудлууд байна. Гэхдээ ямар ч л байсан жосоохон цаг давчуу бүх асуудлууд шийдэгдээд байгаа. Өөр нарийн гоё судлаад бас мэргэжлийн хуульч нартайгаа зөвшилцөөд тэгээд гоё нэг ийм тодорхой ийм нийтэд ээлтэй хуулийг батлах юмсан гэж би хувьдаа бодож байна.

Д.Цогтбаатар: Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ер нь нэг хэд хэдэн юмнууд л харагдаад байгаа юм л даа. Энэ дээр бид нар нэг талдаа сэжигтний тухай асуудал яриад байгаа боловч нөгөө талдаа бас хохирогчийн асуудлыг давхар хөндөх ёстой гэж харж байгаа. Бодох ёстой гэж харж байгаа. Яг хөдөө орон нутаг энэ хүүхдийн эрхийн асуудлаар ингээд ажиллаад явж байхад хүндрэлтэй олон асуудлууд үүсдэг л дээ. Одоо тэгээд саатуулчихгүй юм уу? Эргээд саатуулахгүй болохоор зодно, цохино, хүчирхийллийн асуудлууд гээд л ингээд л олон юм хөндөгддөг. Тэгээд энэ дээр нэг хэд хэдэн зүйлсүүд л харагдаад байна. Цагдаагийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн энэ түр саатуулах ажиллагаа нь уг хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар бол гэмт хэрэгтэй тэмцэх нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилготой гэж үзэхээр шинжтэй байгаа. Гэтэл энэ дээр бид нар ямар байдлаар яаж анхаарч тухайн хүнтэй саатуулах харилцааг яаж зохицуулах вэ гэдгийг л нэг талдаа яриад байгаа гэж л ойлгож байгаа шүү дээ.

Саатуулах, түр саатуулах хүний эрхтэй холбоотой байгууллага. Түрүүн Баасанжаргал гишүүн бас хэллээ. Тэмүүжин гишүүн бас хэлсэн. Энэнтэй бас санал нэг байна. Байгууллага болгон дур дураараа хөндөөд баймааргүй байна. Нэгдсэн нэг мөр нэг зарчимд энийг бид нар цаашидаа оруулахгүй бол ингээд байгууллагын тухай хуулиар зохицуулаад яваад байх нь бол цаашидаа бол учир дутагдал гарна аа гэж харж байгаа. Яг ингээд харахаар энэ Үндсэн хуулийн энэ Цэц дээр үүссэн энэ асуудалтай холбоод харахаар түр саатуулах байр гэдэг ойлголт хүртэл өөр өөр утгаар хэрэглэгдэж байгаа нь эрх зүйн тодорхой байдлыг алдагдуулж байгаа юм гэж биччихсэн байгаа

байхгүй юу. Тэгээд энэ чинь өөрөө түр саатуулах харилцаа түр саатуулах байртай холбоотой асуудлууд гээд ингээд эрх зүйн хувьд маш олон асуудлууд нь өөрсдөө тодорхой бус байдалтай байна гэдгийг ингээд дүгнээд бичээд өгчихсөн байх жишээтэй байна. Эрх чөлөөгөө хасуулсан мөчөөс эхлэн судлагдах хүртэлх хугацааг тооцох нь бол Үндсэн хуулийн шаардлага зайлиггүй болж байх жишээтэй. Гэтэл бид нар одоо хэдэн цагаас нь эхлүүлэх вэ, хэдэн цаг байлгах вэ гэдэг асуудлыг хөндөөд явж байх жишээтэй. Тэгээд энэ дээр нэлээн ноцтой юмнууд байна л даа. Энэ түр саатуулах байр нь Монгол Улсын хэмжээнд хэд байгаа талаар тодорхой тоо тогтоогдохгүй байна гэж. Энэ яг юу гэсэн үг вэ? Энийг би сайн ойлгосонгүй. Монгол Улсын хэмжээнд түр саатуулах байрны тоо хэмжээ огт байдаггүй юм байна гэж ойлголоо.

Тэгэхээр энэ дээр бол бас гишүүдтэй яг санал нэгтэйгээр эргээд бас нэлээн сайн ажиллаж байж эргээд энэ асуудлыг хэлэлцэх нь зөв болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Би энэ дээр нэг хэдэн зүйл хэлье гэж бодож байна. Энэ юу шүү одоо сая ярьж байгаа юмнууд би жинхэнээсээ гайхчихлаа. Хүнд хууль төр сануулаад ирээд хэлчхээд тэгээд тэрнийхээ дараа хариуцлагагүй дараа нь барих ажил саатуулах ажил дараа нь явах тэр хооронд хугацаанд ямар ч эрх зүйн үр дагавар байхгүй юм шиг ийм яриа яригдаж эхэлж байна шүү дээ. Тийм биш шүү дээ. Төр хүрч ирээд би танд ийм эрхтэйг чинь сануулж байна гэж халдаж байгаа чинь уяе тэр хүний эрхэд халдаад тэр хүний эрх чөлөөнд халдах процессыг нь харин бид нар та тэгэхгүйгээр хийж болохгүй шүү. Зөвхөн ингэж хийнэ шүү гэж байгаа байхгүй юу. Өнөөдөр гишүүд минь та нар Үндсэн хуулийн цэцийн энэ шийдвэр гараад одоо энэ хууль чинь зогсчихсон

байж байгаа. Хүний эрхийн нөхцөл байдал чинь дордчихсон байж байгаа. Тийм байхгүй юу.

Яагаад гэвэл наадах чинь зохицуулалтгүй болчихож байгаа байхгүй юу. Нөгөө хууль чинь өөрөө байхгүй зогсчихсон байж байгаа юм чинь. Гэтэл анхны өөрийнх нь энэ 26.2 чинь болохлоор ёстой хэдэн цагаар ч хамаагүй хяналтдаа байлгаж явж байгаад түр саатуулах байранд аваачсанаас эхлээд байгаа байхгүй юу. Тийм юмыг чинь өөрчилж байгаа юм. Тэгээд одоо энийг та нар хаанаас төр ингээд үйл ажиллагаа эхлэхдээ л өөрөө процедуртай аль нэг цэгээс нь сонгох гээд байна шүү дээ. Энэ чинь бид нар субъектив сонголт хийж өгч байгаа байхгүй юу. Субъектив сонголт хийхдээ эд нарын ажил дээр илүү шалгуур тавих л тухай асуудал. Түүнээс энэ чинь амьдрал дээр тийм учраас энэ субъектив өөрөөр хэлбэл энэний жинг би одоо 10 кг юмыг 9 гэж тооцъё гэж яриагүй байхгүй юу. Энэ бол объектив. Энэ байгаагаараа хэмжигдэнэ.

Энэ дээр чинь бол бид нар хууль тогтоогчид. Эдний юмыг хүний эрхэд халдахыг яаж цаашилуулж өгөх вэ гэдгийг нь л яриад байгаа байхгүй юу. Одоо та нарын ярьж байгаагаар мирандаа зарчим үйлчлүүлэхгүйгээр барьчихаж болно. Тэгээд тэрийг хууль ёсны гэж үзэх гээд байгаа байхгүй юу. Үгүй ээ сая яг тийм юм яригдаж байна. Тэгээд та нарыг сонгоод өгөөч гээд байгаа байхгүй юу. Окэй миранда зарчим тэгвэл муу байна. Тэгвэл та нар энэ анхны хэлэлцүүлэг явж байна. Саналаа хэл л дээ. Ерөөсөө л ийм л тухай асуудал байхгүй юу. Энэ чинь хуулийн анхны хэлэлцүүлэг нээлттэй яваад байна шүү дээ. Зүгээр орж ирээд өө энэ болохгүй, ийм болохгүй, ийм аягүй хүнд байна гээд байгаа нөхцөл чинь энэнээс хүнд байгаад байгаа байхгүй юу.

Өнөөдөр иргэд чинь хуульгүй орчинд харин ёстой цагдаа өнөөдөр бол энэ хууль нь зогсчихсон байгаа юм чинь хэзээ ч барьж яаж ч саатуулж хэдэн ч цагаар саатуулж болох гэж байгаа байхгүй юу. Би тэгэхдээ цагдааг тэгж байгаа гэж хэлэхгүй байна. Мэдээжийн хэрэг тэгэхгүй байгаа байх. Гэхдээ тэр эрх зүйн боломж чинь нээлттэй байгаа бөгөөд энийг бид нар гаргахгүй бол ажлаа хийхгүй байна л гэсэн үг. Ийм л юм байна.

Тэгэхээр энийг би хойшлуулж энэ чинь яг үнэн. Хамгийн хэцүү нь 14 хоногийн хугацаатай байхгүй юу. Нөгөө Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт чинь ороод ирэхлээр чуулган эхэлснээс хойш 14 хоногийн дотор бид нар энийгээ батлаад гаргаад өгөөд явуулах ёстой. Тэгэхээр өнөөдөр та бүгдэд одоо ингээд саналаа хэлье. Яг ингэж томьёолъё гэдэг саналаа хэлэх эрх чинь байж байгаа. Ингээд томьёолъё л доо. Энд ямар нэгэн ажлын хэсэг, бид өөрсдөө ажлын хэсэг гэсэн үг шүү дээ. Тэгэхлээр тэрүүгээрээ. Уянгахыг гийшүүн санал байгаа юм уу? Та хэл дээ. Тэгээд дараа нь Тэмүүжин гийшүүн.

Г.Уянгахыг: Энэ дээр нөгөө 22.2 дээр байгаа гэдэг утгаар л хэлээд байгаа болохоос биш одоо яг ийм нөгөө мярандаа эрх хэрэгжихгүй гэдэг юм яриагүй аль ч гийшүүн хэлээгүй байх гэж ойлгож байна л даа. Тэгэхээр энэ дээр яах вэ ер нь бол санал хэлсэн гийшүүд бараг олонх нь хэлж байгаа. Яг ямар эрх зөрчигдөж эхэлж байгаа билээ тэрийг томьёолж орвол яасан юм бэ гэдэг саналыг дэмжиж байна. Гэнэтийн үеэс гэдэг тодорхой л нэг цэгийг хэлж байгаа учраас. Тэгэхээр энийг яах вэ хэрвээ яг яаралтайгаар гэдэг юм уу тийм ээ 14 хоногийнхоо дотор ямар нэг байдлаар салаа утгагүйгээр ойлгож тайлбарлаж хэрэглэхэд хялбар байх ёстой гэдэг санаагаар оруулж ирэх юм бол тэр холбогдох эрх, үүргийг нь тайлбарлан

чөлөөтэй зорчих эрхийг хязгаарласан үеэс эхлэн тоолно гэдэг юм уу? Тэр талаас нь яг энэ нэг ийм чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж байгаа тэр моментыг хэрвээ бид нар үнэхээр л түр саатуулах гэдэг хугацааг тоолж эхлэх гээд байгаа юм бол тэр чөлөөтэй зорчих эрх Үндсэн хуулийн эрх нь байгаа шүү дээ. Тэгэхээр тэр чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж байгаа тэр моментыг л оруулж өгвөл арай нэг дараагийн түвшний ахиц болох юм болов уу л гэж хараад байна л даа.

Нөгөө талаасаа яг энэ 26.2-ын үйлчлэл зогсчихсон буюу нөгөө тооцож эхлэх хугацаа гэдэг нь байхгүй байгаа тохиолдолд түр саатуулах гэдэг утгаараа л явж байгаа шүү дээ тэ. Тэгэхээр заавал юу гэдэг юм. Нөгөө мирандангийн эрх чинь байхгүй болчихсон биш шүү дээ. 22.2 дээрээ байж л байгаа шүү дээ.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүн үгээ хэл.

Х.Тэмүүжин: Хуучин ингээд энэ 2 томъёолол байсан юм. Өчигдөр тараасан томъёолол болохоор ингэж байгаа юм. 26.1-д заасан хугацааг энэ хуулийн 22.2-т заасныг танилцуулсан үеэс гээд биччихсэн байсан байхгүй юу. Тэгээд эхлэн тоолох бөгөөд тэгээд тэр тийм өмгөөл эрүүлжүүлэх энэ тэр гээд бичсэн тэр илүү байсан юм. Өнөөдрийнх дээр болохоор ингээд 22.2-т байгаа зүйлийн зөвхөн тодорхой нэг хэсгийг тавьчихсан байгаа байхгүй юу. Үндэслэл болгоод. Тэгэхээр би бол зүгээр томъёоллоо сайжруулъя гэвэл өчигдөр тараасан 22.2-т заасныг танилцуулан гээд нэг үйлдэл байх ёстой байхгүй юу? Нэг үйлдэл. Энэ хяналтдаа авсан юм уу? Хуучин бол нөгөө баривчлах гэдэг үгийг хэрэглэдэг байсан юм бид нар. Тэгээд сүүлдээ энэ нөгөө баривчлах гэдэг нь өөрөө нэг ял болоод нэг тийм хариуцлага болоод хууль зүйн хувьд өөр газар бас

хэрэглэгддэг болоод жоохон утгаа алдчихсан юм.

Тэгэхээр цагдаагийн байгууллага байна уу, хууль сахиулах байгууллага тэр иргэний зорчих юм уу, өөрөөрөө байх тэр хөдөлж байх боломжит эрхийг нь хязгаарлаад хяналтдаа авч байгаа үйлдлийг хууль зүйн хувьд ямар нэр томъёогоор илэрхийлэх юм? Нэг тогтсон нэг томъёотой болмоор байна. Тэр нэр томъёогоо бичихвэл болчих гээд байгаа байхгүй юу? Зөвхөн 22.2-т заасныг танилцуулан тэгснээс тоолж эхэлнэ гээд тэгснээс гээд нэг үйлдэл байх ёстой байхгүй юу? Тийм тэгээд даруй танилцуул. Тэгээд тэр танилцуулах бол тусдаа 22.2 дээр үүрэг байж байгаа. Үүрэг байж байгаа. Тэгээд нэг тийм үйлдэл нь бичигдэхгүй учраас гээд нэг юм дутуу байна шүү дээ. Диспозиц дутуу байгаад байгаа байхгүй юу яг үнэндээ. Тэр үйлдлийг томъёолох хэрэгтэй байна, нэг.

Цагдаагийн байгууллага дээр одоогоор тэрийг хэрэглэж байгаа томъёолол байна уу? Хууль дээр ингээд бид нар хайх хэрэгтэй. Хуучин бол би санаж байна. Баривчлах ял, баривчлах шийтгэл гэдэг үг хууль зүйн хэллэгт орж ирээгүй байхад манайд бол баривчлах гэдэг үгийг хэрэглэдэг байсан юм. Баривчилснаар гээд хэрэглэхдэг байсан байхгүй юу. Одоо ингээд нэг тийм өөр нэг үг байна уу? Өөр нэг хууль зүйн томъёолол байна уу? Тэрийг л олчихмоор байна. Тэгээд тэр үг л байхад болчихож байгаа байхгүй юу? Тэгээд илүү дутуу юм хэрэггүй.

Д.Цогтбаатар: Наадах чинь бол харин надад сонсогдож байна. Өөрөөр хэлбэл энэ юу эхлээд Уянгахуушиг гишүүний хэлж байгаагаар одоо тэгээд ч чөлөөтэй зорчих. Ингэхлээр яг л их тодорхой амьдрал дээр өөр юу чөлөөтэй зорчих эрх биш. Яг тухайн зорчуулахгүй угаасаа тухайн газраа түр саатуулаад

машиндаа суулгачихад л наадах чинь эхэлж байгаа байхгүй юу? Тэгэхлээр I тийм томъёоллоо тэгвэл та хэд маань бодоодхооч. Гялс одоохон тэгэхгүй бол зарим гишүүд маань гарч явах гээд саналаа хураахгүй бол болохгүй байна. Нараа гишүүн, тэгээд Сайнзориг гишүүн.

М.Нарантуяа-Нара: Тэмүүжин гишүүн, Уянгахушиг гишүүн 2-ын хэлсэн дээр ингэвэл яасан юм дарга аа? Одоо энэ 22.2-т заасныг танилцуулсан. Танилцуулсан үеэс эхэлж гэж байгаа биз. Энэ дээр бүгдээрээ нэг ийм оновчтой юм оруулъя гээд байгаа. Тухайн этгээдийн зорчих эрх хязгаарлагдсан цагаас эхлэн гэж тооцвол яасан юм. Эс үгүй бол тухайн этгээдийн зорчих эрхийг хязгаарласан цагаас эхлэн гэж оруулж болохгүй юм уу?

Д.Цогтбаатар: Би ингэж байна. Одоо яг энд боловсруулж байна. Зорчих эрхийг хязгаарлана гэнгүүт яг тодорхой юм заачхаж байгаа байхгүй юу. Тэгээд тэрнээс өөр амьдралд нөхцөл гараад ирвэл наадах чинь ажиллахгүй болчихно. Тэгэхлээр ерөөсөө хуулийн хэллэг нь өөрөө түр саатуулах байхгүй юу. Тэгэхлээр сануулж түр саатуулах тэгэх юм бол Уянгахушиг гишүүний юу орчхож байгаа биз дээ, тийм биз.

Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Яг л нөгөө миний хэлж байсан санал яг Тэмүүжин гишүүнийхтэй ч адилхан шүү дээ. Бид хэд нөгөө нэг тодорхой тийм яг нөхцөлүүдийг нь заагаагүй. Байсан нэг нөхцөлөө Үндсэн хууль зөрчсөн гээд тэрийг нь аваад хаячихсан байхгүй юу дарга аа. Магадгүй нэг тохиолдол нь түр саатуулах байранд хийгээд эрх үүргийг нь тайлбарлаад өмгөөлөгч авч болно гэж хэлж байсан нэг тохиолдол

байгаа. Машинд суулгаснаар гээд тэр сүр саатуулах тэр объект гэдэг юм уу эсвэл нөхцөлийг эсвэл энэ сандал дээр сууж бай гэснээс ч гэдэг юм уу ингэж өргөжүүлж энийгээ боловсронгуй болгох ёстой байсан болохоос биш тэр хэсгээ Үндсэн хууль зөрчсөн юм гээд аваад хаячихаар агуулгын хувьд сэргээхэд нэгдүгээрт асуудал ингээд гарч эхэлж байгаа. Тэгэхдээ энийгээ хийхээс өөр аргагүй.

Хоёрдугаарт яах вэ сая бас нэг хөндий бас нэг сонирхолтой сэдвийг Тэмүүжин гишүүн бас хөндөж байна. Энэ нөгөө daten юм байгаа. Энэний чинь дараа arrest тэгээд custody ордог. Тэгээд манай энэ хууль зүйн шинжлэх ухаан чинь эд нарыг нөгөө зааг ялгамжтай бас буулгаж ерөөсөө нутагшуулж хэрэглээгүй ерөнхийдөө бүгд л нэг баривчлах түр саатуулах гээд л ингээд л ялгах гээд л үзээд байгаа юм. Тэгэхээр би бол одоо энэ шүүхийн оролцоогүйгээр хийдэг буюу энэ daten гэдэг энэ процессыг л маш ойлгомжтой яг энэ томъёоллоор ингээд эрх үүргийг тайлбарлаад зогсож байтал гүйгээд алга болчихоор жишээ нь тэр хүний хувийн хэрэг дээр түр саатуулагдсан гэхээс өөр аргагүй болчхож байгаа байхгүй юу. Яагаад гэхээр эрх үүрэг тайлбарлагдаад дууссанаар товлоод эхэлж байгаа учраас.

Тэгэхээр ийм нөхцөл байдал руу орж болохгүй учраас энийгээ маш тодорхой бичье. Яг юу гэдэг юм түр саатуулагдах гэдэг юм уу тэр тухайн иргэний өөрөө өөрийнхөө тэр хүсэл зоригоор хөдөлж болохгүй хаашаа нэг тийшээ явах бололцоогүй нөхцөл байдлыг л бид хэд агуулгын хүрээнд баяжуулж өгөх ёстой байхгүй юу. Тэрийг л би жишээгээр хэлээд байсан юм. Тэр байранд хийснээр нэг тохиолдол юм аа. Машинд, морин дээр суучих эсвэл чи яг энэ дээрээс хөдлөхгүй байж бай. Би тодруулаадахъя гээд над дээрээ жишээ

нь тэр хүний хувийн мэдээллээ өг гээд ингээд зогсож байгаа үйл ажиллагаа байхгүй юу. Энэ бүх үйл ажиллагааг илэрхийлж чадах харин оновчтой үг нь юу вэ л гэдэг дээр бид хэд ярьж байгаа болохоос биш зөвхөн эрх үүрэг буюу мирандагийн зарчим тайлбарласнаар ингээд юм явна гэх юм бол жинхэнэ харин бараг тэнд доор чинь л бужигнаан үүснэ л гэж хэлж байгаа юм. Энэ бол тэр процессыг хийж байхдаа заавал тайлбарлах ёстой. Бид хэд энэ рүү явсан шүү дээ. Эрх үүргээ тайлбарлаж өмгөөлөгч ав. Ар гэртэйгээ холбогдох уу гэдэг зүйлийг чинь заавал хэлдэг зүгээр үйл ажиллагаа байхгүй юу, процесс. Тэгэхээр энэ дээрээсээ л ялгамжтай байгаа ч.

Тэгэхээр манай Хууль зүйн байнгын хорооны би бол өчигдөр орой хараад очиж байж бас тодруулж байж болж байгаа учраас яг томьёол дээр сууж чадсангүй. Тэгэхээр ийм л байдалтай байна.

П.Цогтбаатар: Ийм шүү та нар байна шүү дээ тэр мирандаа зарчим аягүй ноцтой зарчим байхгүй юу даа. Хүнд төр, төрийн мөрдөстэй цагдаа хүрч ирээд хууль сануулж байгаа бол төр тэр хүний эрхэнд ује халдаад эхэлж байгаа юм байхгүй юу. Түүнээс тэгчхээд өө яагаа ч үгүй, тэгээд дараа нь барихаас тооцно гээд ийм юм ярих гээд байгаа бол тэр хийж байгаа үйлдлийн чинь өөрийнх нь эрх зүйн утга учир алдагдчихаж байгаа байхгүй юу. Үр дагаваргүй юм төр ярьж болохгүй иргэдтэй.

Би ингээд шинэ нэр томьёо сая та бүгдтэйгээ ярьж байгаад гаргаж байна. Тэгээд энүүгээрээ санал хурааа хэдүүлээ.

Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг энэ хуулийн 22.2-т заасныг танилцуулж чөлөөтэй зорчих эрхийг

хязгаарлаж эхэлсэн үеэс эхлэн тоолно гэсэн ийм томьёоллоор тэгвэл санал хураачихъя.

Аягүй тодорхой болгоод хэцүү болоод явчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр наад сая Энхбаяр сайдын хэлж байгаа чөлөөтэй миний болгоомжлол, яг нэг тодорхой юм зааж байгаа. Тэр чөлөөтэй зорчих эрхтэй, хамаарахгүй нөхцөл үүсвэл яах вэ? Би тэрийг бол ингээд урьдчилж харж мэдэхгүй байгаад байна шүү дээ. Энэ хуулийг байна шүү дээ тайлбарлаад явахад одоо энд яригдсан бүх юмнууд чинь Хуулийн тайлбарт чинь орно. Хөөе энд, тэгэхлээр харин бид нарын хэлж байгаа итгэлээ тайлбарлахдаа ашиглах байхгүй юу.

Би ингээд дахиад уншиж танилцуулъя гишүүддээ. Энэ гишүүдийн оролцоотойгоор бид нар томьёоллоо бас шинэчилж байна. Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг энэ хуулийн 22.2-т заасныг танилцуулж түр саатуулсан үеэс эхлэн тоолно гэсэн ийм томьёоллоор тэгвэл санал хураагаад явчихъя.

Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Цогтбаатар дарга бас сая нөгөө эвийг нь олоод ерөнхий нэг ийм дундын хувилбар бас гаргаад ирлээ гэж бодож байна. Энийг нь хэдүүлээ ингээд жоохон найруулгын хувьд дэмжээд явчихъя л гэсэн бодол байна. Өөрөөр хэлэх юм бол энэ хуулийн 22.1-д заасан хугацааг тоолох асуудлыг зүгээр саатуулсан үеэс эхлэн тоолно гэдэг л агуулгаар томьёолж байна. Энэ саатуулахад юу гэдэг юм, эрх үүрэг, өмгөөлөгч авах эрх гэдэг юм уу яг таны хэлж байгаа тэр мирандагийн зарчмыг тайлбарлана гээд л явчихъя. Ерөөсөө л яг ингээд явчихад асуудал гарахгүй. Түрүүн бас Энхбаяр сайд энэ

микрофонгүй л хэлээд байх шиг байна. Тайлбарлах 2 вариант байна. Бид хэд саатуулах гэдгийг ийм ийм гээд явна гэхээр юм гоожиж үлдэнэ. Зэрэг гэдэг үгээр ч юм уу ингээд явахаар дараа нь бас хэцүү юу үгүй юу? Тэгэхээр энийг бол шүүхийн практикт практикийн хувьд тогтоох байдлаар явахад нь зүйтэй байх аа. Үгүй ээ үгүй энэ бас тогтоож болно. Энэ чинь угаасаа Үндсэн хуулийн зарчим нь тэр шүү дээ. Аливаа бас хуулийн хэрэглээний нэгдмэл байдлыг хангах асуудал чинь Улсын дээд шүүх тайлбараараа хий гэж болно. Энэ дээр ингээд тайлбарлах шаардлагатай байна гээд хүсэлт гаргах юм. Улсын дээд шүүхийн 25 ширхэг хуралдаж байгаад яг энэнээс илүү бид нараар практик судалгаа энэ тэрээ хийлгэж байгаад машинд оруулснаар, түр саатуулах байранд бас энд сууж бай гэж байснаар оффис дээрээ авчирснаар эсвэл коридорт зогсоосон зэрэг бүх үйлдлүүдийг хийж ойлгох юм байна шүү гэдэг зүйлийг л дараа нь Улсын дээд шүүх тогтоогоод маш богино хугацаанд тогтоогоод өгчихөд бас асуудал ингээд цэгцрээд л явчихна гэж би ойлгож байгаа. Энийг хууль тогтоогч яах юм бол? Дараа нь их уян хатан байдал алдагдана. Улсын дээд шүүх юу вэ гэдэг бас тодорхой цаг хугацаанд бас процедур нэмээд тайлбарлаад энийг өргөжүүлэх агуулга наад зараа ингээд бас явчихна л гэж хэлж байгаа. Ер нь зүгээр яг бид хэд тоочоод байх юм бол барагдахгүй. Нэг зүйл л үлдэнэ. Тэгээд энэ дараа нь хуулиас давсан шийдвэр байлаа ч гэдэг юм уу ийм зүйлүүд явах учраас ийм байдлаар явчихвал яасан юм бэ л гэдэг зүгээр зарчмын санал байна.

Д.Цогтбаатар: Тэгвэл энүүгээр хэдүүлээ саналаа хураагаад явчихъя. Үгүй ээ тэр чинь тэгээд саатуулчхаж байгаа юм чинь. Хэдүүлээ ингэе. Энэ хууль энийг байна шүү дээ гишүүдтэй ярьж байгаад бид нар томъёоллоо илүү баяжуулаад боловсронгуй болгоод

оруулж ирж байна шүү. Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг хүнийг саатуулсан үеэс эхлэн тооцох бөгөөд энэ хуулийн 22.2-т заасныг танилцуулна гэсэн ийм томъёоллоор хэдүүлээ саналаа хураачихъя тэгэх үү?

Тэмүүжин гишүүнд микрофон өгье.

Х.Тэмүүжин: Би микрофонд нэг үг хэлмээр байна. Энхбаяр, Сайнзориг 2-ын хэлж байгаа шиг Дээд шүүх тайлбарлачих байх, хэрэглээгээрээ тайлбарлачих байх гэдэг байдлаар бид нар үлдээх бас өрөөсгөл. Энэ дээр 2 концепцын зөрөө гарах юм.

Нэгдүгээрт юу гарах вэ гэхээр манайх шиг парламентын тэгээд эх газрын тогтолцоо бүхий улс орнуудад шүүхийн активизмыг хязгаартай барихыг хичээдэг. Тэгээд шүүхийн активизмыг хязгаартай барихыг хичээдэг учраас шүүхэд хуулийг эрх зүйг хэрэглээн дээрээ шууд ингээд нөгөө академик маягаар тайлбарлаж байгаа юм шиг тайлбарлах эрхийг өгөх гэж оролдох юм бол энийг хууль тогтоох эрх мэдлийг шүүх хэрэгжүүлж байна гэж үздэг.

Тийм учраас хууль тогтоогч нар шүүх рүү хууль тогтоох эрх мэдлийг аль болох хязгаартай шилжүүлэх гэдэг концепцынхоо хүрээнд хууль дээрээ хууль тогтоогчийнхоо тайлбарыг ер нь тухайн цаг үедээ нөхцөл байдалдаа хүрсэн түвшиндээ боломжоороо тайлбарлаж байх ёстой гэдэг ийм хууль тогтоогчийн үүрэг байгаа байхгүй юу.

Тийм учраас бид ч гэсэн одоо энэ саатуулснаар гэдэг үгээр биччихээд Хууль сахиулах ажиллагааны хууль орж ирвэл сайн байна. Орж ирэхгүй бол энэ хууль дээрээ дахиад ард нь Хууль зүйн байнгын хороо ажиллаад тайлбар хийх ёстой. Саатуулснаар гэдгийг ингэж

ингээж ойлгоно гээд хамгийн түгээмэл хэрэглэгдэж байгаа хэдийг нь бичээд зэргийг гэж тавьж байгаад тэр зэргийг гэдэг дээрээ шүүхэд тайлбарлах цоорхойг нь үлдээх ёстой байхгүй юу. Ингээж хууль зүйн техникээ шийдэхгүй бол энийг шүүх ард нь тайлбарлачихна гэх юм бол Энхбаярын ноднин уржнан хэрэгжүүлэх гэж байгаа концепц эвдэгдэнэ. Энхбаяр ноднин уржнан хэрэгжүүлэх гэж нэг концепцоо Дээд шүүх зөвхөн хууль хэрэглээний тайлбар гаргах учраас дотроо кэйс дээр хэрэг шийдвэрлэх явцаа тайлбар хий гэдэг концепц руу бид нар явсан шүү дээ. Үндсэн хууль дээр угаасаа ийм байгаа. Тэгэхээр яг Уянгахишигийн хэлж байгаа үнэ нөхцөл гарч ирээд бид нар хүний эрх зөрчигдөхийг зөвшөөрөөд тэгээд тэрнийхээ араас сайжраг гээд хууль тогтоогч ажлаа залхуурч байгаа юм шиг харагдана гээд Уянгахишигийн хэлээд байгаа чинь бас үнэн байхгүй юу.

Д.Цогтбаатар: Үгүй ээ эсрэгээрээ би ингэх гээд байхгүй юу. Тэр саатуулна гэдэгт зорчих эрхийг хязгаарлах шууд орно шүү дээ. Энэ хүний ярьж байгаа ороод байгаа байхгүй юу. Энэ хүн Бурхан багш биш гэж би бодож байна. Тэгэхээр энэнээс давсан өөр нөхцөл байдал үүсэхийг би хэлж мэдэхгүй байхгүй юу. Та бид нарын хэн ч энд хэлж мэдэхгүй байгаад байна шүү дээ. Тэгэхээр таны хэлж байгаа зорчих эрхийг хязгаарлах бол орж байгаа. Энд саатуулна гэдэгт энэ орохгүй байна гэж яриагүй шүү дээ. Тэрнээс өөр бодит байдлаар ямар нэгэн саатуулагдах нөхцөл үүсэхийг хэлж мэдэхгүй учраас өөрөө зааж байгаад зэрэг гээд явж болно гээд тэгж байна шүү дээ. Энэ бид нарын одоо яг энэ хэлэлцүүлээд байгааг дараа нь хууль хэрэглэхэд хэн ч энэ дээр чинь гол яригдсан юм энэнд бүүр орж байгаа юм бол энэ зорчих эрхийг хязгаарлаж байгаа орж байгаа шүү гээд хэнд ч ойлгомжтой бид яриад байна

шүү дээ. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Протокол дээр юу гэж тэмдэглэж үлдээх ёстой вэ гэхээр одоо саатуулах гэдэг үгийг хуульд өөр хаана хэрэглэж байгаа вэ? Түр саатуулах гэдгээр л хэрэглэж байгаа байх тэ? Түр саатуулах. Тэгснээс биш баривчлах хорихыг саатуулах гэж ерөөсөө хэрэглэхгүй байгаа. Тийм. Тэгэхээр түр саатуулах байранд аваачсанаа зөвхөн саатуулах гэдгээр уламжлалт байдлаар хэрэглэх гэж оролдож байсан тэр хэрэглээ чинь энд хэрэглэгдэхгүй шүү гэдгийг протоколд тэмдэглэж үлдээгээд энэ саатуулах гэдэг үгийг Хууль зүйн байнгын хороо хууль тогтоогчийн хувьд хэрэглэхдээ бараг социализмын үед баривчлах гэж үг хэрэглэж байсан тэр хэлбэр дээр хэрэглэж байна шүү гэж хэлэх ёстой байхгүй юу. Социализмын үед юуг хэлж байсан бэ гэхээр гудамжнаас хүнийг бариад аваад явах. Ямар нэг Уянгахишиг гишүүний хэлээд байгаа нөгөө зорчих эрхийг хязгаарлах хүнийг өөрийнхөө хүслээр ямар нэгэн чөлөөтэй зорчих үйлдэл хийхгүй байгаа тэр үйлдлийг хийхдээ бол баривчлах гэж хэлж байсан байхгүй юу. Социализмын үед. Гэтэл бид нар 20-иод жилийн өмнөөс эхлээд баривчлах гэдгийг нэг ял болгоод хэрэглэчихсэн байхгүй юу. Тэгээд хууль зүйн хэл нь өөр ойлголт дээр хэрэглэгдээд явчихсан.

Тэгэхээр яг энэ нэг хүнийг баривчлаад ингээд нэг хяналтдаа авч байгаа үйлдлийг хэлэх нэр томъёо нь байхгүй байсан учраас одоо саатуулах гэдэг үгээр хэрэглэлээ шүү. Энэ саатуулах гэдэг үг дотор чинь одоо ерөнхийдөө протокол дотор машиндаа суулгах цагдаагийн албан хаагч миний машинд ороод суу гээд иргэнээ машиндаа суулгах, гавлах гудамжинд хяналт тогтоогоод энд зогсож бай гээд зогсоох, дуудаж авчирсныхаа дараа та

энэ манай байгууллагаас гарахгүй шүү. Энэ энэ ажиллагаа дуустал гээд тэр байгууллагадаа барьж үлдээх гэх мэтчилэн ингээд ийм үйлдлүүдийг саатуулах гэдэг дотор ойлгож эхэллээ шүү гэдэг ийм тэмдэглэгээ протоколтойгоор саатуулахыг ингэж ойлголоо. Энэ саатуулах гэдэг бол түр саатуулах үйл ажиллагааны эхлэлийн, эхлэх цэгийг тэмдэглэсэн хууль зүйн нэр томъёо боллоо гэж хаашаа ч хөдлөх, хаашаа ч хөдлөхгүйгээр.

Д.Цогтбаатар: Одоо ингэе. Бид нар ингээд наадахыг чинь бас хэлэлцэх бид нар дэгийн хуультай шүү дээ. Энэ Дэгийн хуулийг би үнэхээр чөлөөтэй энд ярина. Түүнээс би энд санал хураагаад л тэгээд л унавал уна л биз. Ингэж болохгүй байхгүй юу даа наадах чинь цаана нь яг сая Алтангэрэл сайдын хэлж байгаа энэ хууль хэрэгжээд хүмүүсийн амьдрал дээр яваад байна шүү дээ. Тэгээд энэ дээр хүний эрхийг зөрччихсөн байхад одоо бол цагдаагийн албан хаагч хариуцлага хүлээхгүй болчихсон, тэр хууль нь үйлчлэхгүй болчихсон байж байгаа байхгүй юу. Үгүй ээ мэдэхгүй энэ заалт чинь байхгүй болчихсон байгаа гэдгийг анхаараарай. Сая тэгээд протоколд хэлээд үлдээж байна шүү дээ. Би үлдээлгээж байна.

Энүүгээрээ хязгаарлаж байж саатуулсан уншаад хэдүүлээ явчихъя тэгээд ер нь саатуулсан гэдгийг дараа нь илүү тодорхой болгох ёстой гэдэг би бас чиглэлийг өгчихье. Тийм. Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг хүнийг саатуулсан үеэс эхлэн тооцох бөгөөд энэ хуулийн 22.2-т заасныг танилцуулна гэсэн ийм томъёоллоор санал хураалт.

Тэгэхээр хэдэн хувь болох вэ? Отгонбаяр гишүүн. Горимын санал Отгонбаяр гишүүн гаргах уу? Тийм микрофоныг нь өгье.

У.Отгонбаяр: Горимын санал гаргая. Санал өгсөн боловч эсрэг гарсан. Хүчингүй болгоод дахин санал хураах горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. 64 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд түрүүн уншиж танилцуулсан томъёоллоор дэмжье гэсэн томъёолтойгоор санал хураалт явуулъя. 58 хувиар санал дэмжигдлээ.

Сая бид нар ингээд юу дэмжлээ. Гэхдээ энэ саатуулсан гэдэг үгэн дээр ер нь цаашидаа энэ илүү тодруулах шаардлага байна аа. Тэгээд холбогдох байгууллагууд энэ дээр бас ажиллах ёстой. Бас гишүүд энэ дээр санаа оноогоо нэмж хэлээрэй гэдгийг би протоколд хэлж үлдээж байна. Яагаад гэвэл энэ үнэхээр жижиг асуудал юм шиг боловч энэ бол ардаа жижиг асуудал биш. Хувь хүний эрхийн тухай асуудал яригдаж байгаа учраас нарийвчилж ингэж ярьж байгаа нь зөв гэж үзэж байна аа. Ингээд 2 дугаар асуудалдаа оръё.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн ийм горимын санал би гаргаж байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.24-д хуулийн төслийн талаар зарчмын зөрөөтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно гэж

заасны дагуу горимын санал гаргаж байгааг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Хэн танилцуулах вэ? Уначихлаа шүү дээ.

Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье.

Д.Цогтбаатар: Дахин санал хураалгаж өгөөч ээ. Сая дэмжсэн тул микрофон болсонгүй ээ. Энэ саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 52 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүний томъёоллоор санал хураалтыг дахин явуулъя аа. саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

58 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир танилцуулна.

12.36 цагт

Дараагийн асуудалдаа оръё.

Сонгон шалгаруулалтын бүртгэлийн хугацааг тогтоож хүсэлт материал хүлээн авах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Тогтоолын төслийг та бүгдэд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Сонгон шалгаруулалтын бүртгэлийн хугацааг тогтоож хүсэлт материал хүлээн авах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Тэмүүжин гишүүн дэмжсэн байна. Протоколд оруулъя. 58.8 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ талархал илэрхийлье.

12.38 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ,
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯД
АГМАА